



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны захиалгаар
Татварын ерөнхий газрын үйл ажиллагаанд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан



ИЛҮҮ ДАЙЧИЛСАН БОЛОН УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР
ЦААШИД ТӨСВИЙН ОРЛОГОД СӨРГӨӨР НӨЛӨӨЛНӨ

Агуулга

<p>Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:</p> <p>ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</p> <p>Захирал Б.Баттуяа</p> <p>Аудитын менежер Г.Гүнжидмаа</p> <p>Нэгдүгээр хэлтсийн Ахлах аудитор Л.Эрдэнэчулуун</p> <p>Аудитор Ш.Энхтайван</p> <p>Стратегийн удирдлагын Газрын арга зүйч Д.Энхболд</p> <p>2013 оны 1 дүгээр сар</p> <p>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.mnao.mn</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755, 261805 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр Улаанбаатар хот 15160 Монгол Улс</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт 3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл 4</p> <p>Бүлэг 1. Бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл нь үйлчилгээг дэмжсэн, үр нөлөөг тооцсон байх шаардлагатай</p> <p>Оршил 5</p> <ul style="list-style-type: none"> ▪ Бүтцийн өөрчлөлт хийсэн ч зарим нэгжийн чиг үүрэг албан ёсоор баталгаажгаагүй байна 5 ▪ 2012 онд баталсан орон тооны хязгаарыг хэтрүүлсэн байна 5 ▪ Бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл нь үйлчилгээ үзүүлэх тогтолцоог дэмжсэн, үр нөлөөг тооцсон байх шаардлагатай 6 ▪ Байцаагчдын орон тооны жишиг нормативыг баталж мөрдүүлэх нь зүйтэй 8 ▪ ҮТА-нд бүтэц дагасан орон тоог нэмэгдүүлэх шаардлага алга байна 9 <p>Бүлэг 2. Илүү дайчилсан болон урьдчилгаа төлбөр ирээдүйн төсвийн орлогод сөргөөр нөлөөлнө</p> <p>Оршил 10</p> <ul style="list-style-type: none"> ▪ Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын даалгавар өсч иржээ 10 ▪ Төсвийн тодотголоор татварын орлогын төлөвлөгөө 10.6 хувиар буурчээ 11 ▪ 2012 оны татварын орлогын гүйцэтгэл хангагдах боломж муу байна 11 ▪ 2010 оны татварын ногдол орлогын төлөвлөгөөний 56.7 хувийг, 2011 оных 73.3 хувийг эзэлж байна 13 ▪ Дайчилсан болон урьдчилгаа төлбөр цаашид төсвийн орлогод сөргөөр нөлөөлнө 13 ▪ Боломжит эх үүсвэр, нөөц боломжийг шуурхай дайчлах нь зүйтэй 15 ▪ Татвар төлөгчдийн тоо өссөн ч татвар төлөхгүй ААНБ-ууд байсаар байна 15 ▪ УТОХГ-ын хариуцсан том татвар төлөгчдөөс ч тайлангаа ирүүлэхгүй байна 16 ▪ Татварын болон бизнесийн орчны судалгаа хийж, үр дүнг тайлагнах нь зүйтэй 17 ▪ Татварын ачаалал 2011 онд буурчээ 17 ▪ 2012 оны үйл ажиллагаанд 827.7 сая төгрөг дутагдана 18 ▪ Татварын албад орон нутгийн төсвөөс өгч буй мөнгөн хөрөнгийн хөдлөлийг санхүүгийн нэгдсэн тайланд тусгахгүй байна 19 ▪ Татварын орчин, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг дэмжсэн хөрөнгө оруулалтын бодлого үгүйлэгдэж байна 19 ▪ ҮТА-ны үр ашигт ажиллагааны түвшин буурах хандлагатай байна 21
--	--

-Үргэлжлэл -

<ul style="list-style-type: none"> ▪ Зохих шийдвэр, дэмжлэгтэйгээр мэдээлэл авах, солилцооны чиг үүрэг хүлээлгэсэн зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгтэй байна 	21
Бүлэг 3. Татвараас зайлсхийхтэй тэмцэж буй ажлын үр нөлөө хангалтгүй байна	
Оршил	23
<ul style="list-style-type: none"> ▪ Цагдаа, Шүүх, ШШГА-тай хамтран ажиллах ажлын үр дүн хангалтгүй байна ▪ Төлөвлөгөөт шалгалтын үр дүн бүрэн болон сэдэвчилсэн шалгалтын үр дүнгээс бага байна ▪ Томоохон компаниудын өр хүчингүй болжээ ▪ Цагдаа, прокурорын байгууллагад шилжүүлсэн хэргийн дөнгөж 0.03 хувь нь шүүхийн байгууллагад шилжжээ ▪ Шүүхэд шилжүүлсэн иргэний хэргийн 24.2 хувь буюу 46 хэрэгт холбогдох 267.4 тэрбум төгрөг, нийт зөрчлийн 57.0 хувь он дамжин хянагдаж байна ▪ Гүйцэтгэлийн журмаар хийгдэж буй өрийн барагдуулалт хангалтгүй байна ▪ Дотоод аудит, хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтсийн чиг үүрэг зөвхөн үнэлгээ өгөхөөр л хязгаарлагдаж байна ▪ Ногдуулалтын хяналтыг эхлүүлжээ ▪ ААНОАТ-ын тухай хуульд оруулсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох тухай өөрчлөлтийн дүнд 2010, 2011 онуудад нийт 60.2 тэрбум төгрөгийн орлогод ногдох татварыг хөнгөлжээ ▪ Татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай хэлэлцээрийг бүхэлд нь хянаж үзэх нь зүйтэй ▪ Дал эдийн засагтай тэмцэх үйл ажиллагааг дэмжих нь зүйтэй ▪ Жишиг үнэ тогтоох, түүнийг мөрдөхөд нэгдсэн ойлголт, аргачлалтай байх нь зүйтэй 	23 23 24 25 25 26 27 28 28 30 31 32
Дүгнэлт	33
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:	
1. Сангийн яамнаас ирүүлсэн санал	34
2. Татварын ерөнхий газраас ирүүлсэн санал	36
Саналд өгсөн тайлбар:	
Сангийн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар	42
Татварын ерөнхий газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар	43
Зөвлөмж	44
Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал	45
ХАВСРАЛТУУД	46

Товчилсон үгийн жагсаалт

ААН, ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АБТ	Агаарын бохирдлын төлбөр
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТХ	Аймгийн татварын хэлтэс
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ДАХШҮХ	ТЕГ-ын Дотоод аудит, хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтэс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДТХ	Дүүргийн татварын хэлтэс
ЗБҮӨАТ	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар
МСХ	ТЕГ-ын Мэдээлэл, статистикийн хэлтэс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТГ	Нийслэлийн татварын газар
ОАТ	Онцгой албан татвар
ОНТ	Орон нутгийн төсөв
ОТБ	Орон тооны бус
ОУВС	Олон улсын валютын сан
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЕХ	Татварын ерөнхий хууль
ТТХЭ	Татвар төлөгч хуулийн этгээд
ТХХ	ТЕГ-ын Татвар хураалтын хэлтэс
ТХШАЗХ	ТЕГ-ын Татварын хяналт шалгалт, арга зүйн хэлтэс
ТУАБ, ТУБ	Татварын улсын ахлах байцаагч, Татварын улсын байцаагч
УИХ	Улсын Их Хурал
УТОХГ	Улсын төсвийн орлого, хяналтын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮТА	Үндэсний татварын алба
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХХС	Хүний хөгжил сан
ХЭЗХ	ТЕГ-ын Хууль эрх зүйн хэлтэс
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны санал, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Татварын ерөнхий газрын үйл ажиллагаа, түүний дотор улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөлт, үр дүнгийн байдлыг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, аудитын үр дүнг мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд доорх чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- ТЕГ-ын зохион байгуулалтын бүтэц, өөрчлөлтийн үр нөлөө
- Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөлт ба гүйцэтгэл, үр дүн
- Татвараас зайлсхийхтэй тэмцэж буй ажлын үр нөлөө

Хамарсан хүрээ

Аудитыг Сангийн яам болон ТЕГ, түүний бүтцийн нэгжүүд болох УТОХГ, НТГ, зарим ДТХ-ийг хамруулан 2010, 2011, 2012 оны эхний хагас жилийн татварын орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн болон ТЕГ-ын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, үр дүнтэй холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- УИХ болон Сангийн сайд /төрийн захиргааны төв байгууллага/-аас ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн талаар гаргасан шийдвэр, түүнчлэн УИХ-ын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн байдлыг судлан үнэлж дүгнэх,
- Холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл судалгаа гаргуулан шинжлэх, үнэлэх,
- Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх,
- ТЕГ-аас сүүлийн жилүүдэд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ажлын хэрэгжилтийн байдлыг түүвэрчлэн шалгах, түүнтэй зэрэгцүүлэн мэдээллийн бусад эх үүсвэртэй тулган баталгаажуулах, санал асуулга авах, тохиолдлыг судлах арга хэрэглэх, хуулийн этгээдтэй ярилцлага хийх,
- Татвараас зайлсхийхтэй тэмцэж буй ажлын үр нөлөөг судлах, энэ чиглэлээр хэрэгжиж буй тогтолцооны хэлбэр, хэрэгжүүлэлтийн явцад тулгарч буй бэрхшээлийг тандах, уг асуудлаар нэмэлт мэдээлэл олж асуудал боловсруулах,
- Аудитын дүнг баталгаажуулах зорилгоор татварын байгууллагад ажиллагсад болон татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдээс өнөөгийн татварын тогтолцоо, эрх зүйн орчин, ҮТА-наас явуулж буй ажил үйлчилгээнд үнэлгээ өгүүлэх, санал асуулга авах.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын талбар дээрх үе шатны ажлыг ГАГ-ын Нэгдүгээр хэлтсийн ахлах аудитор Л.Эрдэнэчулуун, аудитор Ш.Энхтайван, Стратегийн удирдлагын газрын арга зүйч Д.Энхболд нар хийж гүйцэтгэв.

Бүлэг 1. Бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл нь үйлчилгээ үзүүлэх тогтолцоог дэмжсэн, үр нөлөөг тооцсон байх шаардлагатай

Оршил

УТА нь ТЕХ-д зааснаар татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй¹, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байгууллага² юм.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-ийн “Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах” заалтын дагуу Сангийн сайдын 2011 оны 217 дугаар тушаалаар шинэчлэн баталсан зохион байгуулалтын бүтцийг мөрдөн ажиллаж байна. /ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийг Хавсралт №1-д үзүүлэв/

УТА нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагчаас бүрдэнэ. Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын төсвийн орлого, хяналт, сургалт, бүртгэл мэдээлэл, хэвлэлийн харьяа нэгжтэй байж болно. (ТЕХ-ийн 19.1, 19.2 дугаар зүйлээс)

Бүтцийн өөрчлөлт хийсэн ч зарим нэгжийн чиг үүрэг албан ёсоор баталгаажуулаагүй байна

1.1 Шинэчилсэн бүтцээр “Дотоод аудит, хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтэс”, “Мэдээлэл технологийн төв” зэрэг нэгж нэмэгдсэн ба өмнөх тушаалаар батлагдсан “Эрсдлийн удирдлагын хэлтэс”, “Татварын удирдлага хамтын ажиллагааны газар”, “Санхүү хөрөнгө оруулалт аж ахуйн тасаг” зэрэг нэгжүүдийн чиг үүргийг тусгасан бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Сангийн сайдаар батлуулаагүй байна.

1.2 Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн ТЕГ-ын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Сангийн сайд баталгаажуулах ёстой. ТЕГ-аас 2011 онд батлагдсан энэхүү шинэ бүтцийн дагуу нэгжүүдийн чиг үүргийг албан ёсоор батлуулах хүсэлтээ Сангийн яаманд 3 удаа хүргүүлсэн ч тодорхойгүй шалтгаанаар хойшлогдсоор байна. Өөрөөр хэлбэл, УТА-ны зарим нэгжийн чиг үүрэг тодорхойгүй байна.

1.3 УТОХГ-т Эрсдэлийн удирдлага, судалгаа үнэлгээний /ЭУСҮХ/, Эрдэс баялаг, уул уурхайн татварын /ЭБУУТХ/ хэлтсүүдийг шинээр байгуулсан байна. /УТОХГ-ын зохион байгуулалтын бүтцийг Хавсралт №1.1-д үзүүлэв/

2012 онд баталсан орон тооны хязгаарыг хэтрүүлсэн байна

1.4 УТА-ны орон тоо 2010 оноос хойш жил бүр нэмэгдсээр ирсэн байна.³ Тухайлбал, 2010 оны 12 сарын байдлаар албаны нийт орон тоо 1746 байсан бол 2012 онд 1813 болж өссөн байна.

¹ ТЕХ-ийн 22 дугаар зүйл. Үндэсний татварын албаны чиг үүргийг тодорхойлсон 22.1.2, 22.1.3 дахь заалт

² ТЕХ-ийн 27 дугаар зүйл. Үндэсний татварын албаны удирдлага, түүний бүрэн эрхийн 27.1 дэх заалт

³ **ТЕГ-ын ажлын тайлан-2010 он:** “2010 онд 1746 албан хаагч ажилласнаас 1473 төрийн захиргааны албан хаагч, 273 үйлчилгээний албан хаагчтай, үүнээс ТЕГ-т 103, УТОХГ (35), НДТХ-т 729, АТХ-т 914 албан хаагч ажилласан.

ТЕГ-ын ажлын тайлан-2011 он: “2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 1793 албан хаагч, үүнээс ТЕГ 123, УТОХГ 61, нийслэл, ДТХ-т 690, АТХ-т 919 албан хаагчтай байна”

1.5 ТЕГ-аас энэ хугацаанд орон тоог нэмэгдүүлэх үндэслэлээ дараах байдлаар тодорхойлж иржээ. Үүнд:

- *Ашигт малтмал, ураны салбарт татварын эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх, татвар ногдуулалт, татвар хураах, татварын хяналт-шалгалтын ажлыг дагнан гүйцэтгэх мэргэшсэн нэгжийг ТЕГ-т байгуулах зайлшгүй шаардлагатай тул тухайн нэгжид ажиллах 10 орон тоог төсөвт тусгах,*
- *Албаны бүтцэд хуулийн албыг анхлан байгуулснаас хойш жил бүр хуульчдын орон тоог дэс дараатайгаар нэмж, улмаар орон нутгийн татварын алба бүрт хуулийн мэргэжилтний нэг орон тоог бий болгох зорилгоор ҮТА-ны хэмжээнд хуулийн мэргэжилтэн-татварын улсын байцаагчийг ажиллуулах бодлогын хүрээнд хуульчид ажиллах орон тоог нэмэгдүүлэх,*
- *2012 онд Үндэсний татварын албыг бэхжүүлж, мэдээллийн өндөр технологи, инновац, мэдлэгт суурилсан, дэлхийн жишигт нийцсэн алба болох зорилтыг хэрэгжүүлэх, албанаас хураан төвлөрүүлэх орлогын хэмжээ, татвар төлөгч ААНБ, иргэдийн тоо жил бүр нэмэгдэж байгаатай холбогдуулан татварын албаны орон тооны дээд хязгаарыг 2000 байхаар тогтоох саналтай байгаагаа илэрхийлсэн байна.*

1.6 Хүсэлтээс үзэхэд орон тоо жил бүр нэмэгдсэн, цаашид ч нэмэгдүүлэх шаардлагатайг ТЕГ илэрхийлж ирснийг харж болно. Гэвч уг саналын үндэслэл болох нарийвчилсан тооцоолол, судалгаа хангалтгүй, тухайлбал Сангийн яаманд хүргүүлсэн 2000 албан хаагчтай болгох санал нарийвчилсан тооцоололгүй байна.

1.7 ТЕГ-ын даргын 2012 оны 137 дугаар тушаалаар ҮТА-ны нийт орон тоог 1803-аар баталсан бөгөөд 2012 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 1813 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Засгийн газрын 2012 оны 43 дугаар тогтоолоор ТЕГ-ын орон тооны дээд хязгаарыг 129 байхаар тогтоосон ч өнөөгийн байдлаар 135 хүн ажиллаж байна.

Бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл нь үйлчилгээ үзүүлэх тогтолцоог дэмжсэн, үр нөлөөг тооцсон байх шаардлагатай

1.8 ҮТА-ны хэмжээнд 2010 оны 12 дугаар сарын 31-нээс 2012 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаарх хүний нөөцийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний өөрчлөлтөд хийсэн судалгаагаар нийт ажилтны тоо 276-аар нэмэгдэж, 209-өөр буурчээ. Нийт нэмэгдсэн ажилтны тоонд шинээр нэмэгдсэн 115, бусад албадаас 112 ажилтан шилжин ирж ажиллажээ. /Хавсралт №2-т үзүүлэв/

1.9 Харин тус системд ажиллаж байгаа ажилтнуудын бүрэлдэхүүнд 148 “хураагч”-аас гадна 138 “орон тооны бус байцаагч” /ОТБ/ ажиллаж байна. Хуулийн дагуу⁴

Хяналтын болон хураалтын 1 байцаагч тус бүрт хэдэн нэгж ногдож буй, татварын орлого, тайлангийн төрөл тус бүрээр зарцуулах хугацаа, баримт материалын тоо хэмжээ, ААН-үүдийн үйл ажиллагааны цар хүрээ, ААН болон иргэдийн татварын мэдээлэлтэй танилцах, ногдуулалтын хяналт хийхэд ямар хугацаа зарцуулж байгаа, “хураагч” болон ОТБ байцаагчдын оруулж буй хувь нэмэр, татвар цуглуулахад орон тоо өсгөх бус бусад оновчтой хувилбараар зохицуулах нөөц боломж байгаа эсэх талаар тодорхой, нарийн тооцоо судалгаа дутагдалтай байна.

Улмаар татвар төлөгч ААН, иргэд өсөхийн хэрээр татварын бүтэц, орон тоо тэлсээр л байх уу? гэдэг асуудал ч тавигдаж байна.

Төсвийн дэмжлэгтэйгээр ҮТА-ны цахим хөрөнгө оруулалт нэмэгдсэн, Цахим татварын алба болох зорилтыг стратеги бодлогодоо тусган хэрэгжүүлж байгаа ч энэхүү хөтөлбөр татвар төлөгчдөд үзүүлэх ямар үйл ажиллагааг хэрхэн хөнгөвчилж, орлого бүрдүүлэх, цуглуулахад ямар ашигтай, үр нөлөөг үзүүлэн арвилан хэмнэлтэд хүргэхийг тооцож дүгнэсэн нарийвчилсан тооцоолол алга байна.

⁴ ТЕХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.1-ийн “Татварын улсын байцаагчийн эрх олгохоос өмнө 1 жилийн туршилтын хугацаагаар дагалдангаар ажиллаж байгаа татварын ажилтанг хураагч гэнэ”

хураагч ажиллуулж байгаа ч ТУБ болгон дэвшүүлэн ажиллуулахдаа мэргэжлийн шалгалт авч тэнцсэн хүнийг байцаагчаар томилдог болохоос Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалт явуулахгүй байна.

1.10 УТА-ны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд ажиллах бүрэлдэхүүний үндсэн албан тушаалыг "... татварын улсын байцаагчаас бүрдэнэ" гэж тодорхойлсон.⁵ УТА-ны үндсэн бүтцийн нэгжүүдэд ажиллаж буй бүрэлдэхүүний дийлэнх нь ТУАБ, ТУБ-ын эрхтэй ажилтан ажилладаг. Тэгвэл удирдах бүрэлдэхүүний хувьд 17-оос илүү хувийг ахлах байцаагч, хэлтсийн дарга нар бүрдүүлж байхад нийт байцаагчдын 20 илүү хувь нь хяналт шалгалтын улсын байцаагчид байна. /Бүтцийн нэгжүүдэд ажиллаж буй нийт бүрэлдэхүүний судалгааг Хавсралт №2.1-д үзүүлэв/

1.11 УТА-наас хэрэгжүүлэх бодлого стратегийнхаа хүрээнд татвар төлөгчдөд үзүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлаа чанаржуулж, хүний нөөцийн чадавхиа дээшлүүлж, ажлын байрны хуваарилалтыг оновчтой хийвэл орон тоог өсгөх шаардлага бага байна.

1.12 Түүнчлэн зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор дурдвал зохих асуудал бол өнөөгийн татварын байгууллагын бүтцийн чиг үүрэгт хяналт, хураалт, ногдуулалтын үүрэг илүү давамгай байна. Энэ нь татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд хэт анхаарсан, хураалтын хойноос ихээр хөөцөлдөх ажилд үйл ажиллагаагаа чиглүүлдгээс улбаатай байна.

1.13 Өнөөгийн байдлаар татвар төлөгч өөрөө татвараа тодорхойлж буй хэлбэрийн хувьд татвар төлөгчдөд ухамсартайгаар татвараа төлдөг байх сэтгэл зүйг төлөвшүүлэх, уламжлагдсан болон татвараас зайлсхийх сэтгэл зүйг өөрчлөхөд илүү анхаарах ёстой.

1.14 Гэвч өнөөдөр энэ байдал хангалтгүй байна. Татварын байгууллага орлого биелүүлэхэд түлхүү анхааран, зарим тохиолдолд урьдчилсан татвар буюу илүү төлөлт хийлгэдэг зэрэг нь ямар ч аргаар хамаагүй хураалт, ногдуулалтыг чухалчилж, төрийн нэрийн өмнөөс татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ хоцрогдож байгаагийн жишээ юм.

1.15 УТОХГ-т хяналт шалгалтын байцаагч 40 хүн ажиллаж байхад "Нэг цэгийн үйлчилгээ"-ний нэгжид 5 хүн ажиллаж байна. Ажлын ачааллын нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор "тохиолдлыг судлах арга"-ыг ашиглан Баянгол, Хан-уул ДТХ-ийн "Нэг цэгийн үйлчилгээ"-ний ажилтнуудаар хамгийн их ачаалалтай ажилласан гэх нэг сар, өдрийн татвар төлөгчдөд үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээг гаргуулан ачааллын тооцооллыг хийв.

1.16 Баянгол ДТХ-ийн хувьд хамгийн их ачаалалтай бүтэн сарын хугацаанд нийт 13 байцаагч 12841 хүнд үйлчилсэн байна. Үүнийг өдөр, цагт шилжүүлэн тооцвол нэг байцаагч сард 987 хүнд, өдөрт 44 хүнд, цагт 5 хүнд үйлчилсэн тооцоо гарч байна.

1.17 Хан-Уул ДТХ-ийн "Нэг цэгийн үйлчилгээ"-ний ажилтнуудын хамгийн ачаалал ихтэй өдөр 842 хүнд 7 байцаагч үйлчилсэн байна. Үүнийг байцаагч тус бүрт ногдуулж үзвэл өдөрт 1 байцаагч 120 хүнд ямар нэгэн үйлчилгээ үзүүлсэн нь цагт 15 үйлчлүүлэгчтэй харилцсан гэсэн тооцоо гарч байна.

⁵ ТЭХ-ийн Дөрөвдүгээр бүлэг. 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг

1.18 Харин тус хэлтсийн хамгийн их ачаалалтай гэж тооцсон 1 сарын хугацаанд 7 байцаагч 6437 хүнд үйлчилсэн байна. Үүнийг нэг байцаагчид шилжүүлэн тооцвол 1 байцаагч сард 919 хүнд, өдөрт 41 хүнд, цагт 5 хүнд үйлчилсэн тооцоо гарч байна.

1.19 Дээрх байдлаас үзэхэд ачаалалттай гэж тооцсон сар, өдрийн татвар төлөгчдөд үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээг хэвийн гэж үзэж болохоор байна.

1.20 ТЕГ үйлчилгээндээ тодорхой хэмжээгээр анхаарч 2010 онд “Хуман фортис” ХХК-иар нэг цэгийн үйлчилгээний ажилтнуудын ажлын чанарт дүүрэг, байцаагч тус бүрээр үнэлгээ хийлгэсэн ч өөр бусад байдлаар үр дүнд чиглүүлэн хийсэн дорвитой ажил дутагдалтай байна. Цаашид үйлчилгээ үзүүлэх талыг чухалчлах тогтолцоог дэмжсэн хүртээмжтэй үр нөлөө бүхий ажлыг хийх шаардлагатай байна.

Байцаагчдын орон тооны жишиг нормативыг баталж мөрдүүлэх нь зүйтэй

1.21 "Татварын улсын байцаагчдын орон тооны жишиг норматив"-ыг Сангийн сайдын 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 42 дугаар тушаалаар баталж, 2008 оныг хүртэл мөрдсөн. Уг тушаалыг Сангийн сайдын 2008 оны 38 дугаар тушаалаар хүчингүй болгосон байна. Энэхүү орон тооны жишиг норматив нь орон тооны хязгаарыг тодорхойлох, ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд чухал үүрэгтэй байсан ба цаашид дахин шинэчлэн батлах шаардлага бий болсон байна.

1.22 Өсөн нэмэгдэж буй нийгмийн хэрэгцээ шаардлага, бизнесийн хүрээ, ААН-ийн өсөлттэй холбоотойгоор улсын байцаагчдын орон тооны жишиг нормативыг шинэчлэн батлах хэрэгцээ байгааг үндэслэж Сангийн яамны захиалгаар 2010 онд МУИС-ийн Математик, компьютерийн сургуулийн “Математик хэрэглээ баг” төрийн бус байгууллагаар ҮТА-ны орон тоо, ажлын ачааллын судалгааг хийлгэсэн байна.

МУИС-ийн МКС-ийн Математик хэрэглээ багийн судалгааны дүгнэлтээсУБ.,2010 он

*Татварын системийн ажлын ачаалал болоод орон тооны өнөөгийн байдлыг нийт улсын хэмжээнд авч үзвэл ОУВС-аас гаргасан УТОХГ–т нэмж ажиллуулах шаардлагатай байгаа 46 орон тоог оруулан тооцоод нийтдээ **10 орон тоог хасаж цомхотгох боломжтой** байна.*

*Нийт татварын системийн хувьд **хураалтын байцаагчийн тоог 35-аар, хяналтын байцаагчийн тоог 6-аар цөөрүүлэх, ХАОАТ хариуцсан байцаагчийн тоог 24-өөр нэмэгдүүлэх, харилцах хэлтсийн байцаагчийн тоог 1-ээр цөөрүүлэх** шаардлагатай. Энд дотоод зохион байгуулалт (шилжүүлэг) хийгдэх ба аймаг сумдаас зарим байцаагчийг хот руу шилжүүлэх шаардлагатай байна.*

Аймгуудын татварын газруудаас ажлын ачаалал хамгийн бага байгаа газар тус бүрээс 11,10,10,10 орон тоог цомхотгох, эсвэл өөр бусад аймаг, дүүрэг рүү шилжүүлэх боломжтой байна. Харин ажлын ачаалал хамгийн их байгаа газарт нийт 9 орон тоо нэмэх шаардлагатай байна.

Нийслэлийн дүүргүүдийн хувьд БЗД, БГД, ЧД-ийн татварын хэлтсүүд ажлын ачаалал хамгийн өндөр байгаа бөгөөд тус бүрдээ 27, 19, 17 орон тоо нэмэх шаардлагатай байна. Харин ХУД-ийн татварын газрын ачаалал хамгийн бага байгаа бөгөөд 16 орон тоог цомхотгох, эсвэл өөр дүүргийн татварын газарт шилжүүлэх боломжтой байна.⁶


1.23 Судалгааны үр дүнг ТЕГ үйл ажиллагаандаа хэрэгжүүлээгүй байна. Учир шалтгаанаа судалгааны багийн бүрэлдэхүүнд татварын ажлын онцлогийг мэдэх, татварын байгууллагын ажлын талаар тодорхой туршлагатай хүн оролцоогүй тул бодит нөхцөлтэй нийцэхгүй дүгнэлт гарсан гэж үзсэн байна.

⁶ Эх сурвалж: МУИС, МКС-ийн “математик хэрэглээ баг”-ийн судалгааны дүгнэлтээс, УБ, 2010 он

ҮТА-нд бүтэц дагасан орон тоог нэмэгдүүлэх шаардлага алга байна

График 1.1

1.24 Аудитын хүрээнд ТЕГ, УТОХГ, нийслэл, дүүргийн зарим албадын байцаагч, удирдах ажилтнуудын дунд хийсэн **“Таны ажиллаж буй хэлтэс, газрын хувьд ажлын ачааллыг орон тоотой харьцуулахад хэр зохистой байна вэ?”** гэсэн санал асуулгад дараах дүн гарсан байна.



1.25 Хариултаас үзэхэд 54.6 хувь орон тоог нэмэгдүүлэхгүй ажиллах бололцоотой гэж үзсэн бол 43.8 хувь нь ер нь ачаалалтай тул орон тоог нэмэх хэрэгтэй гэж үзсэн байна. /График 1.1/

1.26 Оролцогчдын 61.5 хувь нь татварын байгууллагад 10-аас дээш жил ажилласан, 23.1 хувь 5-9 жил ажилласан хүмүүс байгаа нь ажлаа илүү сайн мэдэх, үндэслэлтэй хариулт өгөх чадвар бүхий оролцогчид гэдгийг баталж буй юм.

1.27 Судалгаанд оролцогчдын санал бараг тэнцүү хуваагдсан байдал ажиглагдаж байгаа ба үндсэндээ орон тоо нэмэгдүүлэхгүйгээр зохицуулах боломжтой гэсэн хариулт давамгайл хандлагатай байгааг анхаарч, дээрх бусад байгууллагын судалгааны дүгнэлтүүдтэй харьцуулан үзэх, нөөцөд суурилсан чиг үүргийн судалгаа хийх хэрэгтэй гэсэн дүгнэлт хийж байна.

1.28 ҮТА-ны зохион байгуулалтын бүтэц, хүний нөөцийн сонголт, бүрэлдэхүүний өөрчлөлтийг хийхдээ төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэх ажил үйлчилгээг цомхтгосон, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг дэмжсэн хэлбэрээр зохицуулахын зэрэгцээ татварын ногдол тооцох, орлого цуглуулах, өр барагдуулах, зөвлөгөө өгөх зэрэг өөрийн чиг үүргээ хөнгөвчлөх агентийн тогтолцоог судалж, нэвтрүүлэх цаг иржээ.

1.29 ҮТА-ны үйл ажиллагааг судалгаанд оролцогч талууд бараг ижил буюу дунджаас дээгүүр түвшинд үнэлсэн бөгөөд нарийвчлан үзвэл ТУБ-дын ёс зүй, мэдлэг чадвар, хураалтын үйл ажиллагааг татвар төлөгчид илүү үнэлсэн байхад, татварын ажилтнууд шүүмжлэлтэй ханджээ.

1.30 Харин тогтолцоо болон ногдлын хяналтыг татварын ажилтнууд нааштай үнэлсэн байхад татвар төлөгчид шүүмжлэлтэй ханджээ. /Хүснэгт 1.1/

Хүснэгт 1.1
Татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээд, татварын ажилтнуудын үнэлгээний харьцуулалт, /дундаж үнэлгээ/

Үнэлгээний үзүүлэлтүүд	Татварын ажилтан	Татвар төлөгч
Татварын албаны үйлчилгээ	3.8	3.8
Татварын байцаагчдын ёс зүй	3.5	3.6
Татварын байцаагчдын мэдлэг чадвар	3.4	3.7
Татварын тогтолцоо	3.6	3.4
Татварын хууль тогтоомжийн хэрэгжилт	3.4	3.4
Татвар ногдуулалт	3.5	3.4
Татвар хураах үйл ажиллагаа	3.5	3.7

Бүлэг 2. Илүү дайчилсан болон урьдчилгаа төлбөр ирээдүйн төсвийн орлогод сөргөөр нөлөөлнө

Оршил

Үндэсний Татварын алба 2012 оны эхний хагас жилд улсын төсөв, хүний хөгжил санд 1053.8 тэрбум, орон нутгийн төсөвт 251.5 тэрбум төгрөг, нийт 1.3 их наяд төгрөгийн татварын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс нийт 1.1 их наяд төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 89.3 хувийн биелэлттэй байна.

Татварыг татварын төрөлд ангилах ба тодорхой төрлийн татварын харилцааг энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна. ҮТА “улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. ҮТА-ны үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг төсвөөс санхүүжүүлнэ. (ТЕХ-ийн 7.1, 22.1.3, 26.1 дүгээр зүйлээс)

Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын даалгавар өсч иржээ

2.1 Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн татварын орлогын сүүлийн 4 жилийн судалгаанаас үзэхэд нийт орлогын зонхилох хэсгийг буюу 50.0 орчим хувийг татвараар бүрдүүлж байна. /Хүснэгт 2.1/

Үзүүлэлт	2008 он	2009 он	2010 он	2011 он
Нийт орлого	2 170.4	1 994.0	3 122.5	4 468.2
Үүнээс, ТЕГ	1 166.0	938.8	1 545.6	2 159.5
Эзлэх хувь	53.7	47.1	49.5	48.3

2.2 ҮТА-ны улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын батлагдсан төлөвлөгөөг сүүлийн 3 жилээр буюу тайлант хугацааг өмнөх онтой харьцуулан өсөлтийн хувиар тооцон үзэхэд тогтмол өсч ирснийг судалгаа харуулж байна.

2.3 Тухайлбал, 2003-2009 онуудын батлагдсан төлөвлөгөөний өсөлтийн дундаж үзүүлэлтээс харахад улсын төсөвт төвлөрүүлэх орлого 138.3 хувь, өмнөх онтой харьцуулахад 2010 онд 167.3 хувь, 2011 онд 167.3 хувь, 2012 онд 118.2 хувь, 2012 оны эхний 6 сарын байдлаарх батлагдсан хуваарийг өмнөх оны мөн үетэй жишихэд 156.3 хувийн өсөлттэй байна. /Хавсралт №3-т дэлгэрэнгүйг үзүүлэв/

2.4 Харин татварын төлөвлөсөн орлогын гүйцэтгэл 2002-2009 онуудад дунджаар 114.7 хувийн, 2010 оны гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 112.1 хувиар, 2011 оны гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 102.5 хувийн өсөлтийг харуулж байна. /Хавсралт №3.1-ийг үзнэ үү/

2.5 Улсын төсөвт 2010-2012 онд төвлөрүүлэх татварын орлогын санал, батлагдсан төлөвлөгөөг хүснэгт 2.2-т үзүүлэв.

Хүснэгт 2.2

Үзүүлэлт	2010 оны			2011 оны			2012 оны		
	Орлогын санал	Өргөн барьсан санал	Батлагдсан төсөв	Орлогын санал	Өргөн барьсан санал	Батлагдсан төсөв	Орлогын санал	Өргөн барьсан санал	Батлагдсан төсөв
Улсын төсөв	423 343,4	578 271,5	940 288,4	729 664,4	1106458,9	1524 624,6	1636 815,4	2094 912,6	2 100 156,1
ААНОАТ	151 284,4	235 050,2	268 802,2	348 580,1	385 465,0	591 746,1	602 472,2	758 677,5	767 178,9
НӨАТ	140 129,3	175 585,0	175 585,0	180 269,7	301 800,0	343 500,0	402 267,1	582 890,3	582 890,3
ЗБҮӨАТ	-	-	310 624,9	-	-	73 900,0	-	-	-

АМНАТ	58 321,2	76 393,3	94 033,3	105 397,7	280549,9	366 734,6	511 439,9	581 839,9	578 582,0
ОАТ	73 608,5	91 243,0	91 243,0	95 416,9	108 644,0	110 144,0	97 709,0	137 504,9	137 504,9
АБТ	-	-	-	-	30 000,0	30 000,0	22 927,2	34 000,0	34 000,0
Бусад	-	-	-	-	-	8 600,0	-	-	-

2.6 Хүснэгтээс үзэхэд ТЕГ-аас 2010 онд улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын саналыг батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 516.8 тэрбум төгрөг буюу 122.1 хувиар, 2011 оны санал 794.9 тэрбум төгрөг буюу 108.9 хувиар өссөн байна.

2.7 Харин 2012 онд улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын саналаа 1636.8 тэрбум төгрөгөөр тооцон хүргүүлж байсан бол Сангийн яам 2094.9 тэрбум төгрөг болгон өргөн мэдүүлж, 2100.2 тэрбум төгрөгөөр хуульчлагдсан нь 463.3 тэрбум төгрөг буюу 128.3 хувиар өссөн байна.

2.8 ТЕГ-аас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын саналаа сүүлийн 3 жилийн судалгаа, том татвар төлөгчдийн бизнесийн чадамж, ажлын төлөвлөгөө зэрэг зохих нөөц бололцоонд суурилан төлөвлөж байгаа боловч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хууль тогтоох байгууллагад өргөн барьсан болон улсын төсвийн тухай хуулиар төвлөрүүлбэл зохих татварын орлогын хэмжээ нэмэгдсэнийг харж болно.

2.9 ТЕГ нь хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу татварын төлөвлөгөөг биелүүлэхээр ажиллаж байгаа боловч биелэлтэд үндэслэл муутай, хэт өндөр төлөвлөгөө сөргөөр нөлөөлдөг гэж тайлбарлаж байна.

Төсвийн тодотголоор татварын орлогын төлөвлөгөө 10.6 хувиар буурчээ

2.10 Улсын эдийн засгийн төлөв, байдал улсын төсөв болон ХХС-гийн гүйцэтгэлд дотоод болон гадаад орчны хүчин зүйлсийн нөлөөлөл, төсөвт тодотгол хийх үндэслэл, шаардлагын дагуу УИХ-аас баталсан 2012 оны төсвийн тодотголоор анх баталсан татварын нийт орлого 10.6 хувиар буюу 254.9 тэрбум төгрөгөөр буурсан байна. /Хүснэгт 2.3/

Хүснэгт 2.3		/тэрбум төгрөг, %/			
		2012 оны төсвийн		Өөрчлөлт	
Татварын төрөл	төлөвлөгөө	тодотгол	тоо	хувь	
Нийт	2 100,2	1 878,5	- 221,7	89,4	
ААНОАТ	767,2	703,2	- 64,0	91,7	
НӨАТ	582,9	582,9	-	-	
ОАТ,	137,5	170,8	33,3	124,2	
Үүнээс:	Архи	91,9	113,0	21,1	123,0
	Тамхи	19,1	31,2	12,2	163,7
	Пиво	26,6	26,6	-	100,0
АМНАТ	578,6	396,3	- 182,2	68,5	
АБТ	34,0	25,3	- 8,7	74,4	

2012 оны татварын орлогын гүйцэтгэл хангагдах боломж муу байна

2.11 Улсын төсөвт төвлөрүүлэх 2100.2 тэрбум төгрөгийн татварын орлогоос 2012 оны эхний 6 сарын байдлаар 906.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд ХБГ-ээр 1836.0 тэрбум төгрөг буюу 87.4 хувийг бүрдүүлэхээр тооцож байв.⁷


2.12 Харин төсвийн тодотголын дагуу Сангийн яамнаас хийсэн шинэчилсэн хуваарийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг 2012 оны 6 ба 9 дүгээр сарын байдлаар авч үзэхэд, оны эхний 6 сарын

⁷ Эх сурвалж: ТЕГ-аас гаргаж байсан “Улсын төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл”-ийн судалгаа

байдлаар төлөвлөгөө биелсэн байдалтай, харин 9 сарын байдлаар 1222.9 тэрбум төгрөг буюу 94.5 хувиар хангагдаж гүйцэтгэл 71.0 тэрбум төгрөгөөр дутуу байна.

График 2.1

2.13 Улсын төсөвт 2012 онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө болон 2012 оны III улирлын гүйцэтгэлийн нийт дүнд тухайн татварын төрөл тус бүрээрх хувийн жинг тооцож үзэхэд ААНОАТ, НӨАТ, АМНАТ нь улсын төсвийн зонхилох хэсгийг бүрдүүлэх ач холбогдол бүхий татвар болохын хувьд нийлбэр дүнгээр нийт татварын орлогын 90.0 гаруй хувийг эзэлж байна. /График 2.1-ийг үзнэ үү/



2.14 2012 оны IV улиралд хуваарийн дагуу 584.5 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэх ёстой болж байгаа бөгөөд ХБГ-ээр 27.5 тэрбум төгрөгийн орлого дутахаар тооцоологдсон нь 2012 оны орлогын төлөвлөгөөний биелэлт хангагдах боломж бага байгааг илтгэж байна.⁸

Хүснэгт 2.4

2.15 Татварын сүүлийн 4 жилийн судалгаанаас үзэхэд ногдуулалт ба төлөлтийн хэмжээ дунджаар төлөвлөгөөт үзүүлэлтэд хүрээгүй, нийт төлөлт нь төлөвлөгөөтэй харьцуулахад 13.5 тэрбум, ногдлоос 9.2 тэрбум төгрөгөөр дутуу байжээ. Үүнийг хэрэглээ болон үйлдвэрлэлд шахсан төлөвлөгөө гэж үзэж болохоор байна. /Хүснэгт 2.4-ийг үзнэ үү/

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН СУДАЛГАА /сүүлийн 4 жилд/			
Үзүүлэлт	Нийт дүн /сая төгрөг/		
	Төлөвлөгөө	Ногдол	Төлөлт
2008 он	81 649,8	77 388,8	68 536,1
2009 он	66 676,4	71 975,9	64 892,1
2010 он	107 392,4	94 543,9	91 572,5
2011 он	116 144,0	82 971,4	92 661,8
Бүгд	371 862,5	326 880,0	317 662,5
Дундаж	92 965,6	81 720,0	79 415,6

2.16 Харин АМНАТ-ын төлөвлөгөө 9 сарын мэдээгээр 56.3 тэрбум төгрөгөөр буюу 119.9 хувиар биелсэн боловч ХБГ-ээр 96.7 тэрбум төгрөгөөр дутагдахаар байна.⁹

2.17 Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын бүрдүүлэлтэд доорх хүчин зүйлс нөлөөлснөөс биелэлт хангалтгүй түвшинд байна. Үүнд:

- Гадаад орчны хүчин зүйлс буюу хөрш улсын эдийн засгийн бууралт, импортын бодлого,
- Гол нэр төрлийн стратегийн түүхий эдийн /зэс, боловсруулсан нүүрс, коксжих нүүрс, чулуун нүүрс, төмрийн хүдэр зэрэг/ үнэ, олборлолт, экспорт анх төлөвлөж байсантайгаа харьцуулахад багассан, Жишээ нь: зөвхөн нүүрсний ачилтыг авч үзэхэд олборлогч ААН-үүдийн 2012 оны төлөвлөгөө 31.8 сая тонн байсан бол ХБГ-ээр 16.1 сая тонн байна.
- Зам хааснаас орлого тасарсан,
- ААНОАТ болон АМНАТ-ын ногдлын бууралт
- Нөөцөөс давсан орлогын төлөвлөгөө¹⁰

⁸ Эх сурвалж: ТЕГ-ын Татвар хураалтын хэлтсийн мэдээллээс

⁹ Эх сурвалж: ТЕГ-ын Татвар хураалтын хэлтсийн “2012 оны татварын орлогын ХБГ-ийн мэдээлэл”

¹⁰ Эх сурвалж: ТЕГ-ын тайлбар

2010 оны татварын ногдол орлогын төлөвлөгөөний 56.7 хувийг, харин 2011 оных 73.3 хувийг эзэлж байна

2.18 Тайлант хугацааны ногдлын хэмжээг төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 2010 оны III улиралд 56.7 хувь, 2011 оны III улиралд 73.3 хувь, 2012 оны 10 сард 92.6 хувийг тус тус эзэлж, харин ногдлын хэмжээг хураалтын түвшинтэй харьцуулахад 2010 онд 50.9, 2011 онд 72.6, 2012 оны 10 сарын эцэст 98.9 хувийг эзэлж байна.¹¹ /Хүснэгт 2.5/

/тэрбум төгрөг/

Татварын Төрөл	Төлөвлөгөө	2010 оны		Төлөвлөгөө	2011 оны		Төлөвлөгөө	2012 оны 10 сар	
		←Ногдол	Хураалт		←Ногдол	Хураалт		←Ногдол	Хураалт
Нийт	1 109,5	629,5	1 235,7	1 635,8	1 199,4	1 652,2	1 485,6	1375,4	1 389,9
ААНОАТ	309,3	254,5	390,9	598,8	443,4	630,6	566,8	406,5	471,3
НӨАТ	233,3	207,7	207,7	410,4	365,2	365,8	453,5	523,8	384,2
ЗБҮӨАТ	349,5	-	423,2	73,9	-	55,9	-	-	-
АМНАТ	110,0	93,6	117,2	398,0	305,0	481,9	315,9	352,1	409,1
ОАТ	107,4	73,7	91,6	116,1	85,5	92,4	125,6	77,8	93,5
АБТ	-	-	-	30,0	0,3	19,8	23,9	15,2	19,7
Бусад	-	-	5,2	8,6	-	5,9	-	-	12,1

2.19 Хүснэгтээс ногдлын хэмжээ төлөвлөгөө болон хураалтын түвшнээс бага байгааг харах бөгөөд төлөвлөгөөний биелэлтийг хангахын тулд бусад эх үүсвэрийг дайчлах, татварын баазыг нэмэгдүүлэх, татвар төлөгчдийн бизнесийн таатай орчинг сайжруулах чиглэлээр тодорхой алхмууд хийх хэрэгтэйг харуулж байна.¹²

2.20 ҮТА-дын хяналт шалгалтын ажлын үр дүнд төлүүлж барагдуулсан 2010, 2011, 2012 оны эхний хагас жилийн мэдээллээс үзэхэд тухайн тайлант хугацааны ногдлоос бүгд 46472.6 сая төгрөг буюу тус бүртээ 14518.1, 24990.0, 6964.6 сая төгрөгийг барагдуулсан бөгөөд тухайн тайлант хугацаанд төвлөрүүлсэн нийт татварын орлогын гүйцэтгэлийн дүнд эзлэх хувийн жинг авч үзвэл 1.3, 1.5, 0.8 хувийг тус тус эзэлж байна.

2.21 Татварын хяналт шалгалтын үр дүнгээр илрүүлсэн барагдуулалт нь татварын нийт орлогын зохих хувийг эзэлж байгаа бөгөөд тухайн барагдуулалтын дүнг тайлант хугацааны эцэс дэх өрийн үлдэгдлийн дүнд ямар хэмжээтэй байгааг авч үзэхэд 2010 онд 46.5, 2011 онд 57.5, 2012 оны эхний хагас жилд 12.6 хувийг тус тус эзэлж байна.

2.22 Хяналт шалгалтаар хугацаандаа төлөөгүйн алданги, нөхөн төлбөр, торгууль хүү ногдуулан тодорхой хэмжээний орлогыг төсөвт төвлөрүүлж байгаа ч энэ нь татвар төлөгчдөд дарамт хэлбэрээр тусахыг анзаарах, хүн хүчний нөөцийг зохистой хуваарилах, татварын тайлан хүлээн авах, ногдлын үнэн зөвд хяналт, залруулгыг тухай бүр нь хийж ногдлыг бүрэн төлүүлэх, 1 цэгийн үйлчилгээний хүний нөөцийг эргэн харах, эрсдэлийг тооцсон урьдчилсан шинжилгээний дагуу онилсон тактикийг үр нөлөөтэй хэрэгжүүлбэл зохимжтой юм.

Дайчилсан болон урьдчилгаа төлбөр цаашид төсвийн орлогод сөргөөр нөлөөлнө

2.23 ТЕХ-ийн дагуу татвар төлөгч татварын ногдлоо өөрсдөө тодорхойлдог тогтолцоо нь өр буюу татварын авлага үүсгэх зарчмаар хэрэгжиж байдаг нь улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөлтийн нэг сул тал болж байна.

¹¹ Эх сурвалж: ТЕГ-ын Татвар хураалтын хэлтсийн мэдээллээс

¹² Нэмэлт жишээ: Дэлхийн банкнаас гаргадаг "Бизнес эрхлэхүй" судалгаагаар манай улс 2008 онд 53 дугаарт эрэмбэлэгдэж байсан бол 2012 онд 86 дугаар байр руу ухарчээ.

2.24 Түүнчлэн татварын албадаас татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор ТТХЭ-ээс төлбөл зохих хэмжээнээс давсан татварыг нэхэн төвлөрүүлэх асуудал байдгийг дурдах нь зүйтэй юм.

2.25 Тухайлбал, доорх графикаас үзэхэд¹³

График 2.2

ААНОАТ-2010 он





График 2.3

ААНОАТ-2011 он



Тайлбар: 2010 онд ААНОАТ-аар 390.8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн ба түүнд тухайн жилийн ногдол 254.5 тэрбум төгрөг буюу 65.1 хувийг, харин “илүү дайчилсан татварын орлого 59.2 тэрбум төгрөг буюу 15.1 хувийг”, өрийн үлдэгдэл 13.9 тэрбум төгрөг буюу 3.6 хувийг тус тус эзэлж байна.

Тайлбар: 2011 онд ААНОАТ-аар 630.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн бол түүнд тухайн жилийн ногдол 443.4 тэрбум төгрөг буюу 73.4 хувийг, харин “илүү дайчилсан татварын орлого 232.7 тэрбум төгрөг буюу 36.9 хувийг”, өрийн үлдэгдэл 29.1 тэрбум төгрөг буюу 4.6 хувийг тус тус эзэлж байна.

Гэтэл энэхүү татварын төрлөөрх улсын төсөвт төвлөрүүлэх орлогын даалгавар 2010 онд 309.3 тэрбум төгрөг буюу нийт гүйцэтгэлийн 79.2 хувь байхад 2011 онд 94.5 хувь байна.

2.26 Харин НӨАТ /А/ болон ОАТ-ын /Б/ тухайд авч үзвэл:

Хүснэгт 2.6		А.НӨАТ				/сая төгрөг/	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Илүү дайчилсан татвар		Өрийн үлдэгдэл		
			Дүн	ААН-ийн тоо	Дүн	ААН-ийн тоо	
2010 он	233 281,2	207 721,9	250 226,9	5 690	27 817,8	7 720	
2011 он	410 396,4	365 173,2	350 243,0	7 260	58 294,3	8 865	
Б.ОАТ							
2010 он	255 727,1	231 248,3	5 481,5	65	2 045,1	69	
2011 он	447 057,3	388 875,1	5 133,8	30	2 246,6	71	

2.27 Дурдсан тоо баримт, дүнгээс үзэхэд жил бүр улсын төсвийн орлого давж биелсэн харагдаж байна. Гэвч угтаа бол үндэслэл багатай орлогын төлөвлөгөө биелүүлэх даалгаврыг ТЕГ-т үүрэг болгон өгдөг нь илүү дайчилсан татварыг авахад хүргэж байна.

2.28 Илүү дайчилсан татвараар ТЕГ жил бүр орлогын даалгаврыг биелүүлдэг нь Засгийн газар өөрсдийн төлөвлөгөөг ямар ч байсан биелэх үндэслэлтэй болдог мэт ойлгогддог. Нөгөө талаас ТЕГ ч гэсэн илүү дайчилсан татвар аваад ч хамаагүй үүргээ биелүүлснээр орлогын төлөвлөгөө давуулсны урамшуулал авах боломжтой болдог.

2.29 Энэ нь эцэстээ Засгийн газрын үргүй зардлыг жил бүр тэлж ТЕГ орлогын төлөвлөгөө биелүүлсний төлөө урамшуулал авах, нөгөө талаас татвар төлөгчдөд дарамт учруулж улмаар татвараас зайлсхийх, татвараа худал мэдүүлэх зэрэг сөрөг нөхцлийг ч бий болгох үр дагавартай юм.

¹³ Аудитын багаас ТЕГ-ын ТХХ-ээс гаргуулсан судалгааны тоо баримтад суурилав.

2.30 Түүнчлэн сүүлийн жилүүдэд том татвар төлөгчид болох уул уурхайн компаниудын ирээдүйн татвараас урьдчилгаа төлбөр төлүүлэх, дараа тайлангийн хугацааны зарим өр төлбөрийг хаадаг нь цаашдын татварын орлогын тогтвортой өсөлтийг хангахад бэрхшээл үүсгэх юм.¹⁴

2.31 Тухайлбал, 2011 онд Засгийн газар болон “Оюу толгой” ХХК, “Эрдэнэс МГЛ” компанитай байгуулсан “Урьдчилгаа төлбөрийн гэрээ”-ний дагуу төлбөр авч “Хүний хөгжил сан”-д төвлөрүүлж ирсэн, мөн 2012 он гараад “Эрдэнэт” үйлдвэрээс 100.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт авсан нь дээрх нөхцөлийг үүсгэхээр байна.

Боломжит эх үүсвэр, нөөц боломжийг шуурхай дайчлах нь зүйтэй

2.32 Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын даалгаврын биелэлт ХБГ-ээр хангагдах боломж муу байгаа тул дараахь эх үүсвэр, шинэ бодлого, асуудлыг нэн тэргүүнд дайчлах, судалж шийдвэрлэвэл зохимжтой байна. Үүнд:

Шинэчилсэн орлогын даалгаврыг хэрэгжүүлэх боломж ба нөөц:

- *ҮТА-ны тайлагнаснаар өмнөх онуудаас дамжиж ирсэн татварын өрийг барагдуулах,*
- *Тайлант хугацааны ногдуулалтыг бүрэн төлүүлэх,*
- *Хууль хяналтын байгууллагын шат бүрт хянагдаж буй өрийн асуудлаар төрийн тусгайлсан дэмжлэг авах асуудлыг судалж шийдвэрлэх,*
- *ШШГА-д хяналтанд байгаа өрийн тодорхой хувийг авлага баргдуулах хуваарьт оруулж тохиролцсоны үндсэн дээр төлүүлэх,*
- *Эд хөрөнгөөр барагдуулах асуудлыг татвар төлөгч нартай сайтар тохиролцон борлуулах асуудлыг судалж шийдвэрлэх,*
- *Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг сайжруулах,*
- *Татварын хураангуй, цомхтгосон төрөл хэмжээ, шинэ төрлийн татвар нэвтрүүлэх, амлалт зарлах зэрэг асуудлыг судлах зохион байгуулалтын арга хэмжээг 2013 оноос авч хэрэгжүүлэх шаардлагатай.*
- *Гадаад хүчин зүйлсийн нөлөөлөл, учирч болзошгүй эрсдэлийн судалгааг сайтар хийж байх.*

Татвар төлөгчдийн тоо өссөн ч татвар төлөхгүй ААНБ-ууд байсаар байна

2.33 Сүүлийн жилүүдэд татварын орчинг сайжруулах зорилгоор хувь хэмжээг бууруулсан өөрчлөлт нь татварын ачаалал багасч бизнес эрхлэгчдэд таатай боломжийг бий болгосон, улсын эдийн засгийн өсөлт болон гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн, жижиг дунд үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх сонирхол зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөллөөр бүртгэлтэй ТТХЭ-ийн тоо жил бүр өсч байна.

2.34 Бүртгэлтэй ААН-ийн 2010 оны тоог 2008 оны мөн үетэй харьцуулахад 124.4 хувиар, 2012 оныг 2010 оныхтой харьцуулахад 125.3 хувиар тус тус нэмэгджээ.

2.35 2012 оны 6 дугаар сарын байдлаар нийт 104.0 мянга гаруй хуулийн этгээд бүртгэлтэйгээс хариуцлагын хэлбэрээр буюу 90493 нь ашгийн төлөөх байгууллага, ашгийн бус буюу төсөвт болон ТББ 13875 байна. /Хавсралт №4/

2.36 Тайлангийн ирцийн 2012 оны II улирлын мэдээллээс ААНОАТ-ын төрлийг сонгож үзэхэд тайлан ирүүлбэл зохих 79833 нэгжээс 65962 ирүүлсэн буюу 82.6 хувийн ирцтэй байжээ. Гэвч тайлан ирүүлсэн нэгжээс “Х” тайлан ирүүлсэн 29635 буюу 44.9 хувь, алдагдалтай тайлан ирүүлсэн 10675 буюу 16.2 хувь байна. Нийт тайлангаа ирүүлснээс 25652 буюу 38.8 хувь нь л үйл ажиллагааны үр дүнгийн хувьд зохих

¹⁴ Татварын ерөнхий хуулийн 17.1.4-ийн “илүү төлсөн татварыг буцаан авах буюу суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах”

түвшинд ашигтай ажилласан, дийлэнх нь татвар төлөхүйц хэмжээнд ажиллаагүй гэсэн тооцоо гарч байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №4.1-д үзүүлэв/

2.37 НӨАТ-ын тайлан ирүүлбэл зохих 25246-аас ирүүлсэн 23625 буюу 93.6 хувь, үүнээс “Х” тайлан ирүүлсэн 7907 буюу 33.5 хувь, тайлан ирүүлээгүй 1620, ОАТ-ын тайлан ирүүлээгүй 5, АМНАТ-ын тайлан ирүүлээгүй 56 байна.

2.38 Ирцийн мэдээллээс татварын орлогын зонхилох хэсгийг эзэлдэг ААНОАТ-ын төрлийг сонгон “Х” болон “-” тайлан ирүүлсэн ААНБ-уудын 2010 оны тоог 2008 оны мөн үетэй харьцуулахад 164.1 хувиар өссөн, 2012 оныг 2010 онтой харьцуулахад 143.9 хувиар өссөн байна.

2.39 Бүртгэлтэй татвар төлөгчдийн тоо өсч байгаа ч “Х” болон “Алдагдалтай” тайлан ирүүлж буй нэгжийн тоо буурахгүй байна.

УТОХГ-ын хариуцсан том татвар төлөгчдөөс ч тайлангаа ирүүлэхгүй байна


2.40 Улсын төсвийн татварын орлогын бүрдүүлэлтэд УТОХГ-ын хариуцсан ААНБ-ууд зонхилох үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд нийт 2012 оны эхний хагас жилийн байдлаар ААНОАТ-ын 76.0 хувь, НӨАТ-ын 46.1 хувь, ОАТ-ын 96.4 хувь, АМНАТ-ын татварын 83.0 хувийг тус тус бүрдүүлжээ. /Хавсралт №4.2/

2.41 Гэвч 2012 оны III улирлын тайлангийн ирцийн мэдээллээс үзэхэд тайлан ирүүлбэл зохих 323 ААНБ-аас ирүүлсэн 320, эдгээрээс “Х” болон алдагдалтай тайлан ирүүлсэн 106, тайлан ирүүлээгүй 3 байна. /Хавсралт №4.3-ыг үзнэ үү/

2.42 Татварын ажилтан болон татвар төлөгчид “Х” тайлан ирүүлж буй шалтгааныг хэрхэн тайлбарласнаас үзэхэд бизнесийн тааламжтай бус бодлого, эрх зүйн тогтолцооны нөлөөлөл их гэж ойролцоо түвшинд хариулсан байна. /График 2.4-ийг харна уу/

График 2.4

ААНБ-ууд “Х” тайлан ирүүлдэг шалтгаан:



2.43 ҮТА-ны хэмжээнд 2012 оны III улирлын байдлаар гаргасан ААНОАТ-ын тайлангийн ирц, ногдлын мэдээллээс үзэхэд тайлан ирүүлбэл зохих нийт 82483-аас 80.9 хувь буюу 66748 ирүүлсэн байна.

2.44 Эдгээрээс 42.6 хувь буюу “Х” тайлантай 28409, алдагдалтай 16.3 хувь буюу 10857, ногдолтой 41.2 хувь буюу 27482, тайлан ирүүлээгүй 19.1 буюу 15735 байна. /Хавсралт №4.4-ийг үзнэ үү/

2.45 Тайлангаа ирүүлээгүй байсан 15735 нэгжээс өмнөх 4 улиралд тайлангаа хэрхэн ирүүлж байсан эсэх талаар судалгаа гаргуулан үзэхэд 6003 татвар төлөгч буюу 38.2 хувь нь огт тайлангаа ирүүлээгүй байжээ. /Хүснэгт №2.7-ийг үзнэ үү/

Хүснэгт 2.7

Үзүүлэлт	Тайлант хугацаа				
	2011 оны III улирал	2011 оны IV улирал	2012 оны I улирал	2012 оны II улирал	2012 оны III улирал
Тайлан ирүүлсэн	13 342	14 594	9 700	8 942	-
Тайлан ирүүлээгүй	2 393	1 141	6 035	6 793	15 735
Нийт	15 735	15 735	15 735	15 735	15 735

Тайлан ирүүлээгүй 15735 нэгжийн өмнөх 4 улиралд хэрхэн тайлан ирүүлсэн давтамжийг үзвэл:

огт ирүүлээгүй	1 удаа ирүүлсэн	2 удаа ирүүлсэн	3 удаа ирүүлсэн	4 удаа ирүүлсэн	Нийт
6 003	2 857	2 522	2 012	2 341	15 735

2.46 Тайлангийн ирцийн 2010, 2011, 2012 оны II, III дугаар улирлын байдлаар статистик мэдээллээс үзвэл “Х” болон “-” тайлангийн эзлэх хувь бодитой буураагүй, ногдолтой тайлан 33.3 хувийг л бүрдүүлж байна.

Татварын болон бизнесийн орчны судалгаа хийж, үр дүнг тайлагнах нь зүйтэй

2.47 Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд татварын дарамт болон ачаалал хэрхэн илэрч татвар төлөгчдийн ажил үйлчилгээгээ явуулах бизнесийн орчинд хэрхэн нөлөөлж байгааг мэргэжлийн байгууллагын хувьд үндэслэлтэй тооцож, судлах шаардлагатай байна.

Банк санхүүгийн салбарын ААН-ийн удирдлагатай хийсэн ярилцлагын хэсгээс ... УБ., 2012

Банкны үйл ажиллагаанаас хамаарч дараах санхүүгийн бүртгэл хийгддэг бөгөөд энэ нь татвараас банкуудад дарамтыг үүсгэсээр байна.

Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (ӨБҮХХ) нь зээл, зээлийн хүүгийн төлбөрийн тооцоогоор бусдаас өмчлөн авсан, худалдан борлуулах зориулалттай, банкны үйл ажиллагаанд хамааралгүй үл хөдлөх хөрөнгийг хэлдэг. Иймд зээл, авлагыг барагдуулах зорилгоор банк зээлдэгчтэй байгуулсан гэрээнд барьцаа болгон заасан үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг өөртөө шилжүүлэн авч борлуулах ажиллагааг эхлэнэ. Ийнхүү банкны өмчлөлд шилжсэн хөрөнгийг худалдан борлуулах үед үнийн дүнгээс Үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвар 2 хувь, Нэмээдсэн өртгийн албан татвар 10 хувийг банкнаас татварын байгууллагад зайлшгүй төлдөг. Учир нь банк тухайн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг өөртөө шилжүүлэн авч борлуулах ажиллагааг хийдэг тул татварын байгууллагын зүгээс тухайн хөрөнгийг банкны хөрөнгө гэж үзэн татвар төлөхийг шаардана. Энэ үед эдгээр татварын дүнгээр банкны зардал нэмэгдэнэ.

Нөгөө тохиолдолд Банк ӨБҮХХ-ийг зах зээлийн үнээс бага үнээр борлуулбал үнийн зөрүүгээр Хөрөнгө данснаас хассаны гарзаар бүртгэдэг. Хөрөнгө данснаас хассаны гарз зардал нь ААНОАТ-ын тухай хуулийн 3-р бүлэг болох Албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд ордоггүй тул банк мөн алдагдалтай борлуулсан хэмжээгээр ААНОАТ-ыг төлнө. Иймд ӨБҮХХ-тэй холбоотой дээрх асуудлыг бүртгэлийн хувьд шийдвэрлэх шаардлагатай байна. ӨБҮХХ-ийн эргэн төлөлт нь банкны хувьд орлого бус найдваргүй зээлийн төлөлт байна.

2.48 ҮАГ-аас татварын албадын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг сайжруулж ажлаа олон нийтэд нээлттэй ил тод мэдээлэх үүднээс дутуу хураасан болон татвар авч чадаагүй алдсан татварын тоо хэмжээг тайлагнаж байх нь зүйтэй.

Татварын ачаалал 2011 онд буурчээ

2.49 Монгол Улсын нэгдсэн төсвийн татварын орлогын хэмжээ 2000 онд 315.9 тэрбум төгрөг байсан бол 2011 онд 4066.4 тэрбум төгрөг болж, 12.9 дахин өссөн. Судалгаанаас үзэхэд ДНБ-ий өсөлтөөс татварын орлогын өсөлт өндөр байсантай

холбоотойгоор ДНБ-д татварын орлогын эзлэх хэмжээ буюу “татварын ачаалал” сүүлийн 10 жилийн дунджаар 28.1 хувь байна.

2.50 Татварын ачаалал 2002 онд 30.7 хувь байсан бол 2010 онд 26.4 хувь болж өссөн, харин 2011 онд 22.7 хувь болж өмнөх оноос 14 хувиар буурчээ. /Хүснэгт №2.8/

Хүснэгт 2.8

Үзүүлэлт	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Татварын ачаалал, Нийт	30.7	34.2	30.2	27.5	34.2	35.0	20.8	19.0	26.4	22.7
ААНОАТ-ын	3.7	4.7	4.6	4.3	6.0	4.4	3.9	3.1	4.6	5.0
ХАОАТ-ын	2.1	1.7	1.7	1.7	1.7	1.3	1.6	1.9	1.9	2.1
НӨАТ-ын	6.6	7.7	7.1	6.1	6.1	5.1	5.2	4.9	6.9	10.2
ОАТ-ын	3.9	4.0	3.3	2.8	2.7	2.7	2.7	2.5	3.2	2.7

2.51 Татварын ачаалал буурсан статистик үзүүлэлт нь татварын тогтвортой орчин үйлчилсэн, эдийн засгийн өсөлттэй шууд холбоотой юм.

2012 оны үйл ажиллагаанд 827.7 сая төгрөг дутагдана

2.52 ҮТА-ны үйл ажиллагааны зардлын төсөв, гүйцэтгэлийг авч үзвэл:

Хүснэгт 2.9

/сая төгрөг/

Д.д	Үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр	Тайлант хугацаа					
		2010		2011		2012.09.30	
		Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв*	Гүйц
1	<i>Нийт санхүүжилт</i>	11 194,0	11 978,2	15 605,3	19 485,3	15 824,2	16 913,4
	<i>Улсын төсвийн</i>	11 194,0	11 194,0	15 605,3	15 605,3	15 824,2	15 824,2
	<i>Орон нутгийн төсвийн</i>	-	697,2	-	700,0	-	-
	<i>Өөрийн орлого</i>	-	87,0	-	3 180,0	-	1 089,2
2	<i>Урсгал зардал, Үүнээс:</i>	11 194,0	11 968,6	15 605,3	19 155,5	11 957,8	15 791,2
	2.1 <i>Цалин</i>	7 073,3	7 073,2	9 319,2	9 483,6	9 869,7	9 665,8
	2.2 <i>Томилолт</i>	58,5	58,5	124,2	118,0	136,5	115,4
	2.3 <i>Шагнал урамшуулал</i>	1 044,0	1 329,7	1 313,7	1 274,9	1 301,6	1 136,3
	2.4 <i>ТАХ-ний зардал</i>	2 739,3	3 228,3	4 227,2	7 724,1	3866.4	4 257,8
	2.5 <i>Бусад /бараа, ажил үйлчилгээний зардал/</i>	278,9	278,9	621,0	554,9	650,0	615,9
	<i>2.5.1 Мэдээлэл/суртал</i>	49,6	47,3	78,0	70,5	126,6	91,1
<i>2.5.2 Сургалт/семинар</i>	57,8	57,8	62,0	56,7	85,4	48,8	
3	Хөрөнгө оруулалт	2 108,7	2 162,7	2 790,0	2 774,7	7 550,0	2 227,0
	<i>Нийт эх үүсвэрийн дүн</i>	13 302,7	14 140,9	18 395,3	22 260,0	23 374,2	19 140,4

*Тэмдэглэл: Сангийн яамнаас баталсан төсвийн санхүүжилтийн хуваарийн дагуу авсан болно.

2.53 ТЕГ нь төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим албадад цалин, нийгмийн даатгалын болон ХХОАТ, байр ашиглалттай холбогдох урсгал зардлын өр үүссэн байна. Тухайлбал, ҮТА-ын хэмжээнд ТЕГ-ын санхүүгийн албанаас гаргасан судалгаа, ХБГ-ээр 2012 оны үйл ажиллагаанд бүгд 827.7 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэр дутагдахаар байна.

2.54 ҮТА-ны гол чиг үүргийн нэг нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах¹⁵ боловч зарцуулж буй төсөв санхүүжилтийн нийт дүнд

¹⁵ ТЕХ-ийн 22 дугаар зүйл. Үндэсний татварын албаны чиг үүргийн 22.1.1-ийн заалт

“Мэдээлэл сурталчилгаа”-ны болон “Сургалт семинарын зардал” харьцангуй бага хувийг эзэлж байна.

Татварын албад орон нутгийн төсвөөс өгч буй мөнгөн хөрөнгийн хөдлөлийг санхүүгийн нэгдсэн тайланд тусгахгүй байна

2.55 Сангийн сайдын тушаалаар татварын албаны үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулалд зориулан 2011 онд 453.7 сая төгрөг, 2012 онд 450.0 сая төгрөг олгосноос ТЕГ-ын даргын тушаалаар журмын дагуу ажилтнуудын ажлын үр дүн, биелэлтийг харгалзан урамшуулал олгож иржээ.

2.56 Харин татварын албадад орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлээс хамаарч орон нутаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газраас болзол зарлан, мөнгөн урамшууллыг гэрээний үндсэн дээр тухайн шатны төсвөөс олгож байгаа ч энэ хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал, өнгөрсөн онуудад Баянгол дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг давуулсан бол орлогын 20 хүртэл хувиар, Чингэлтэй, Багануур дүүрэгт төлөвлөгөө давуулсан нөхцөлд 20 хувиар, мөн Баянгол, Чингэлтэй ДТХ-ийн удирдлагад 5 болон 10 хувиар урамшуулал олгож иржээ.

2.57 Төсвийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн үр дүнг харгалзсан, зарим хуулийн заалтыг үндэслэл болгосон зэргээр урамшуулал олгож буй энэхүү тогтолцоо, эрх зүйн орчныг өөрчилж боловсронгуй болгох шаардлагатайг тэмдэглэж байна.

2.58 Хэдийгээр энэхүү хөрөнгөөр албад өөрсдийн материаллаг баазыг бэхжүүлэн ажилтнууддаа мөнгөн тэтгэлэг, урамшуулал олгож байгаа ч энэхүү хөрөнгийн хөдлөл, хөдөлгөөнийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу¹⁶ ҮТА-ны санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгүүлэхгүй байна.

Татварын орчин, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг дэмжсэн хөрөнгө оруулалтын шинэ бодлого үгүйлэгдэж байна

2.59 Хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэлийн дэлгэрэнгүйг авч үзвэл:

Хүснэгт 2.10

/сая төгрөг/

Үзүүлэлт		Тайлант хугацаа						
		2010 он		2011 он		2012 оны 9 сар		
		Төсөв	гүйц	төсөв	гүйц	төсөв*	Гүйц	
Нийт төсөл, арга хэмжээний	тоо	28	28	33	33	39	29	
	дүн	2 162,7	2 162,7	2 790,0	2 774,7	7 550,0	2 227,0	
Үүнээс:	Шилжих барилга	тоо	4	4	2	2	2	1
		дүн	1 258,7	1 258,7	900,0	900,0	3 350,0	500,0
	Их засвар	тоо	11	11	9	9	11	6
		дүн	244,0	244,0	150,0	134,7	200,0	134,4
	Машин, тоног төхөрөмж	тоо	10	10	11	11	8	8
		дүн	550,0	559,0	1 428,5	1 428,5	1 072,3	1 070,0
	Тавилга, эд хогшил	тоо	3	3	4	4	10	9
		дүн	110,0	101,0	72,6	72,6	269,4	264,3
	Програм хангамж	тоо	-	-	7	7	8	5
		дүн	-	-	238,9	238,9	2 658,3	258,3

*Тэмдэглэл: Сангийн яамнаас баталсан төсвийн санхүүжилтийн хуваарийн дагуу авсан болно.

¹⁶ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн “Улсын төсвийн байгууллага тайлагнах журам, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”, Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”

2.60 ҮТА-ны үйл ажиллагааны орчин нөхцлийг сайжруулах зорилгоор улсын төсвөөс олгож буй хөрөнгө оруулалтын хэмжээ жил бүр өсч байна.

2.61 Чингэлтэй ДТХ-ийн барилгын санхүүжилтэд 2011 онд нийт 650.0 сая төгрөгийг улсын төсвөөс олгохоор болж хуучин барилгыг буулгах, суурийн ажил, материал бэлтгэх 682,6 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гэрээнд захиалагч талаас ТЕГ-ын дэд дарга Ж.Батбаяр, ерөнхий санхүүч Г.Баярмагнай, хяналтын инженер Ц.Гэндэн нар баталгаажуулж, 2011 оны 12 дугаар сарын 12-ны өдөр гүйцэтгэгч “Заг” компанид 650,0 сая төгрөг шилжүүлсэн байна.

2.62 2012 оны 10 дугаар сарын байдлаар уг барилгын ажлыг эхлүүлэх, суурь ухах, арматур бэлтгэх, харуул хамгаалалтын зэрэг ажилд гүйцэтгэгчээс бүгд 148,8 сая төгрөгийг зарцуулсан байна. Гэвч газрын маргаантай асуудлаас болж цаашид уг барилга баригдах боломжгүй болжээ.

2.63 Түүнчлэн 2012 онд төсөвлөгдсөн Баянзүрх дүүргийн хэлтсийн барилгын 1843.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаас 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг эхний ээлжинд шилжүүлж энэ ондоо ашиглалтад оруулахаар гэрээ хийгдсэн ч ажлын явц байдлаас үзэхэд төлөвлөсөн хугацаанд ашиглалтад орох боломжгүй болжээ. /Зураг №1-д үзүүлэв/

Зураг №1

Чингэлтэй ДТХ-ийн барилгын ажлын явц
“Барилга барих боломжгүй газар төлөвлөжээ”



Баянзүрх ДТХ-ийн барилгын ажлын явц
“Төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орох боломжгүй”



2.64 Чингэлтэй дүүргийн ТХ-ийн барилгын санхүүжилтээс зарцуулагдаагүй үлдэгдэл 501.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэв.

2.65 Цахим татварын орчинг бий болгох ажлын эхлэлийг төсвийн хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр эхлүүлж ажлын санаачлага гаргаж байгаа боловч 2012 оны нийт санхүүжилтийн 9.7 хувь ашиглагджээ.

2.66 Мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд төрийн байгууллага хооронд болон ялангуяа мэдээлэл солилцоог дэмжсэн, хамгаалалт, нууцын өндөр зэрэглэлтэй, нэгдсэн технологийн шийдэл бүхий бодлого стратегийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байх юм.

2.67 ТЕГ нь аймаг, нийслэл, дүүргүүдэд 32 нэгжтэй бөгөөд эдгээрээс 7 хэлтэс түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байна.

2.68 Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж буй хэлтсүүдийн судалгааг хүснэгт 2.11-д үзүүлэв.

Хүснэгт 2.11

№	Албадын нэр	Нийт ажиллагсад	1 хүнд ногдох талбай /м.кв/	1 мкв-ийн үнэ сараар	1 м.кв-ийн үнэ жилээр	Нийт талбай /м.кв/	Нийт талбайн хөлс жилээр /мян.төг/
1	Говьсүмбэр ТХ	11	11.2	3 500	42 000	123	5 166,0
2	Чингэлтэй ДТХ	94	10.6	1 420	17 000	1 000	17 000,0
3	Багануур ДТХ	19	16.4	5 890	70 674.6	312	22 050,5
4	Баянзүрх ДТХ	102	10.3	27 000	324 000	1 051	340 524,0
5	Сүхбаатар ДТХ	120	10.1	38 395	460 740.7	1 207	556 114,0
6	Хан-Уул ДТХ	69	11.7	4 500	59 975.2	807	48 420,0
7	Багахангай ДТХ	2	-	3 509	42 107.7	26	1 094,8
	ДҮН	417	-	-	-	4 526	990 369,3

2.69 Дээрхээс харахад 1 хүнд ногдох талбайн хэмжээ ойролцоо боловч 1 мкв-ийн үнэ харилцан адилгүй байна. Түүнчлэн хэлтсүүд татвар төлөгчдийн байрыг түрээслэн үйл ажиллагаагаа явуулж жилд ойролцоогоор 1.0 тэрбум шахам төгрөгийг төлж буйд дүгнэлт хийх цаг болжээ.

2.70 Улсын төсвийн дэмжлэгтэйгээр татварын албадыг бэхжүүлэх, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төлөвлөлт, ашиглалт, гүйцэтгэл сайнгүй байна.

ҮТА-ны үр ашигт ажиллагааны түвшин буурах хандлагатай байна

2.71 ҮТА-ны хэмжээнд санхүүгийн болон үр ашигт ажиллагааны мэдээллээс үзэхэд “Татварын орлогын нэг төгрөгт ногдох зардлын тооцоолол”-оор 2010 онд 1.0 мөнгө буюу төлөвлөсөнтэй харьцуулахад 94.1 хувь байсан бол 2011 онд 0.77 мөнгө буюу 107.7 хувь болж сайжирсан гэсэн үнэлгээ өгөгджээ.¹⁷

2.72 Гэвч “Зардлын нэг төгрөгт ногдох орлогын хэмжээ” 2012 оны эхний 6 сарын байдлаар 2010, 2011 оноос түвшнээс буурсан, мөн “Татвар төлөгчийг татварт хамруулсан байдал”, “Татвар хураалтын түвшин”-ий үзүүлэлт буурах хандлагатай байгаад дүгнэлт хийх шаардлагатай болжээ. /Хавсралт №5-д үзүүлэв/

Зохих шийдвэр, дэмжлэгтэйгээр мэдээлэл авах, солилцооны чиг үүрэг хүлээлгэсэн зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгтэй байна

2.73 Татварын албаны мэдээллийн сан бүрдүүлэх ажиллагаа нь төрийн байгууллагын нэгдсэн сүлжээ, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх Үндэсний “Дата төв”-ийн зарим үйл ажиллагаатай давхарддаг байна.

2.74 Иймд татвар төлөхөөс зайлсхийх явдлыг бууруулж, татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, татварын хяналт, шалгалтын ажлыг сайжруулах, татварын нөөц боломжийг нэмэгдүүлэх зорилготой уялдуулан ҮТА-нд шаардлагатай мэдээллийг ТТХЭ болон банк, санхүүгийн байгууллагуудаас авах эрхийг өргөжүүлэх яам, агентлаг зэрэг төрийн захиргааны байгууллагын мэдээлэл боловсруулалт, ашиглалтын ялгааг арилгах, улсын эрх ашгийн үүднээс хоорондын харилцан солилцоог дэмжих, нэгдсэн сүлжээтэй байхуйц зохих шийдвэр, дэмжлэг хэрэгтэй байна.

¹⁷ Эх сурвалж: ТЕГ-ын ДАХШҮХ-ээс “Татварын албад, газар хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн хяналт үнэлгээний тайлангаас

2.75 Учир нь өмнөх аудитаар ч гэсэн хөрөнгийн бүртгэл хариуцсан болон татварын орлого бүрдүүлэгч байгууллагын ажлын уялдаа хангалтгүй, төсвийн орлогыг нэмэгдүүлэх ихээхэн нөөц байгааг илрүүлэн, холбогдох зөвлөмжийг өгч байсан ч энэ асуудал удаашралтай байна.¹⁸

2.76 Шинэ татварыг нэвтрүүлэх, татварын баазыг өргөжүүлэх чиглэлээр зардлын хяналтыг хийх, одоо байгаа нөөцөд тулгуурлан нэвтрүүлэх буюу “Мэдээллийн технологи, шинэ техник, инноваци, аутсорсинг, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон эдийн засгийн шинэ салбарын хөгжлийг эхлүүлэх, төрийн амлалт хэлбэрээр зарлах зэргээр ирээдүйн шинэ татварын баазыг бий болгох, татварын амралт эдлүүлэх боломжтойг санал асуулгад оролцсон татварын албаны ажилтнуудын 39.2 хувь нь дэмжсэн байна. /Хавсралт №6-д үзүүлсэн “Санал асуулга”-ын 6.1 дүгээр асуулт/



2.77 Түүнчлэн “Аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр орлогын албан татварт хамрагддаггүй /ашгийн бус/ байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд бага хэмжээгээр татвар ногдуулах”-ыг оролцогчдын 32.2 хувь нь буруутгаагүй, дэмжсэнийг тэмдэглэж байна. /Хавсралт №6-д үзүүлсэн “Санал асуулга”-ын 6.4 дүгээр асуулт/

¹⁸ Эх сурвалж: ҮАГ-аас 2012 оны эхний хагаст хийсэн “Үл хөдлөх хөрөнгө, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн албан татвар ногдуулалт, хураалтын бодлого, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Бүлэг 3. Татвараас зайлсхийхтэй тэмцэж буй ажлын үр нөлөө хангалтгүй байна

Оршил

ТЕГ-ын ТХШАЗХ нь "ҮТА-ны татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны нэгдсэн бодлогыг тодорхойлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах", "Хууль тогтоомж зөрчсөн талаар ирүүлсэн иргэн, байгууллага, ААН, албан тушаалтны гомдол, мэдээлэл, хүсэлтийг ТЕГ-ын дарга, асуудал эрхэлсэн дэд даргын өгсөн шийдвэрээр комисс томилуулж шалгах ажлыг зохион байгуулах, дүнг танилцуулах", ХЭЗХ нь "ҮТА-ны хэмжээнд татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих", "Шүүхийн шийдвэртэй татварын өрийг барагдуулахад ШШГА-тай хуулийн хүрээнд хамтран ажиллах, албадыг удирдлагаар хангах, зохион байгуулах" зэргээр татвар төлөгчдийн татвараас зайлсхийхтэй тэмцэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Татвар төлөгч холбогдох баримт, бүртгэлд үндэслэн хуулийн дагуу төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлон татварын тайланд тусгаж, бэлэн болон бэлэн бус хэлбэрээр татвар төлнө.

Татварын тайлан тушаах, төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтоох ба татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа адил байна. (ТЕХ-ийн 43.1, 43.5 дугаар зүйлээс)

Цагдаа, Шүүх, ШШГА-тай хамтран ажиллах ажлын үр дүн хангалтгүй байна

3.1 Сангийн сайдын 2011 оны 217 дугаар тушаалаар батлагдсан зохион байгуулалтын бүтцийн хүрээнд 2012 оны 6 сарын байдлаар ҮТА-ны татварын хяналт шалгалтын хэлтсүүдэд 285 байцаагч /20.4 хувь/, хууль эрх зүйн хэлтэс, тасгуудад 38 байцаагч /2.7 хувь/ тус тус ажиллаж байна.

3.2 Мэдээллээс үзвэл үйл ажиллагааны батлагдсан төсвийн 30 орчим хувийг хяналт шалгалтад зарцуулж байгаа боловч шалгалтаар төсөвт оруулж буй орлого 1.3 хувийг эзэлж байна.

3.3 Хяналт шалгалтын ажлын үр дүнг татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэрэгт дүгнэлт бичиж цагдаа, прокурор, шүүхээр шийдвэрлүүлсэн байдлаар дүгнэж үзвэл хангалтгүй дүн үзүүлж байна.

Төлөвлөгөөт шалгалтын үр дүн бүрэн болон сэдэвчилсэн шалгалтын үр дүнгээс бага байна

3.4 Дээр дурдсанчлан хяналт шалгалтаар улсын төсөвт төвлөрүүлж буй орлогын дөнгөж 1.2 хувийг дунджаар төвлөрүүлж байгаа ба хяналт, шалгалтын төрлөөс хамааран түүний үр дүн харилцан адилгүй байна. /Хүснэгт 3.1-ийг үзнэ үү/

Хүснэгт 3.1

ҮТА-НЫ 2011, 2010 ОНД ХИЙСЭН ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН НЭГДСЭН СУДАЛГАА

Д.д	Хяналт шалгалтын төрөл, үндэслэл	Илрүүлсэн зөрчлийн Дундаж		Төлүүлэх шийдвэрийн дундаж		Хуулийн байгуулагад шилжүүлсэн дундаж	
		2011 он	2010 он	2011 он	2010 он	2011 он	2010 он
А. ТАТВАРЫН АЛБАДЫН ДҮН							
1	Дундаж гүйцэтгэл	153.2	82.2	72.0	15.8	2.2	6.6
Үүнээс	Төлөвлөгөөт	150.8	46.5	73.2	9.8	1.2	2.9
	Гэнэтийн	29.6	20.2	4.3	4.8	-	21.0

	Бүрэн	122.5	596.5	12.3	78.3	10.9	131.0
	Сэдэвчилсэн (хэсэгчилсэн)	604.0	627.6	245.0	128.1	-	0.6
	Бусад	119.1	-	25.7	-	36.7	-
Б. ТЕГ-ЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, АРГА ЗҮЙН ХЭЛТСИЙН ДҮН							
2	Бүрэн	2 661.0	1 919.9	996.2	273.7	14.6	1 311.2
	Үүнээс: Бусад байгууллагын шийдвэр, хүсэлт	2 661.0	2 706.5	996.2	406.1	14.6	1 848.0
В. ҮТА-НЫ НИЙТ ДҮН							
3	Дундаж гүйцэтгэл	154.7	89.3	72.6	16.8	1.4	11.4
Үүнээс	Төлөвлөгөөт	150.8	46.5	73.0	9.8	1.2	2.9
	Гэнэтийн	29.6	20.2	4.3	4.8	-	21.0
	Бүрэн	187.4	758.2	37.5	102.2	11.0	275.2
	Сэдэвчилсэн (хэсэгчилсэн)	604.0	627.6	245.0	128.1	-	-
	Бусад	119.1	-	25.7	-	36.7	-

3.5 Дээрх хүснэгтээс харахад төлөвлөгөөт шалгалтаар илрүүлсэн зөрчил, төлүүлэхээр шийдвэрлэсэн дүн, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн зөрчлийн үзүүлэлтүүд нь дундаж хувь болон сэдэвчилсэн хяналтын дунджаас ихээхэн хэмжээгээр бага байна.

3.6 Энэ нь төлөвлөгөөт хяналт, шалгалтын үр дүн нь мэдээллээр болон бусад байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хийгдсэн хяналтын үр дүнгээс бага байгааг харуулж байна.

Ярилцлагын хэсгээс ...УБ., 2012


Татварын алба өнөөг хүртэл ямар хэмжээний орлого, татвар ногдох бусад зүйлийг нуувал акт бичих, аль зэрэг их хэмжээний орлого нуухад дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлэх вэ? гэдгийг нэг мөр тодорхойлоогүйгээс зарим тохиолдолд ихээхэн хэмжээний мөнгөн дүн бүхий зөрчилтэй асуудалд татварын хуулиар өөрсдөө хариуцлага тооцдог, зарим тохиолдолд 10-30 сая төгрөгийн татвараа төлөөгүй хохирол бүхий асуудал дээр дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлэх зэрэг асуудалд өөр өөрөөр хандан ажилладаг.

Томоохон компаниудын өр хүчингүй болжээ

3.7 Татвар ногдуулах, төлүүлэх үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хэлэлцэх анхан шатны нэгж нь “Маргаан таслах зөвлөл” юм.

График 3.1

3.8 ҮТА-нд татварын маргаан таслах 23 зөвлөл ажиллаж байгаа ба 2012 оны эхний хагас, 2011, 2010 онуудад МТЗ-өөр ААН-үүдээс ирүүлсэн гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг авч үзэв. /График 3.1-ийг үзнэ үү/



Ирүүлсэн гомдлын дүн хүчингүй болгох үзүүлэхээр шийдвэрлэсэн

3.10 2012 онд нийт хэлэлцсэн гомдлын Петровича Дачин Тамсаг ХХК-д ногдуулсан 350.0 тэрбум төгрөгийн актыг бүхэлд нь хүчингүй болгосон, 2010 онд нийт хэлэлцсэн гомдлын Таван толгой транс, Эрдэнэт үйлдвэр, Худалдаа Хөгжлийн банк зэрэг ХХК-

иудад холбогдох актуудыг бүрэн болон хэсэгчлэн хүчингүй болгосноор дийлэнх нь цуцлагджээ.

3.11 Үүнээс дүгнэвэл татварын байцаагчдын мэдлэг чадвар дутмагаас үндэслэлгүй акт тавигдаж байна уу?, эсвэл “Маргаан таслах зөвлөл”-ийн асуудлын шийдвэрлэлтэд асуудал байна уу? гэдгийг нягтлах цаг болжээ.

Цагдаа, прокурорын байгууллагад шилжүүлсэн хэргийн дөнгөж 0.03 хувь нь шүүхийн байгууллагад шилжжээ

3.12 Татварын албадаас 2010, 2011 он, 2012 оны эхний хагас жилд 149 дүгнэлтэд холбогдох 884.2 тэрбум төгрөгийн зөрчилд дүгнэлт бичиж шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлсэн бөгөөд шийдвэрлэлтийн явцын статистик мэдээллийг үзүүлбэл:



3.13 Тоогоор нь авч үзвэл нийт 149 зөрчлөөс 2 буюу 1.3 хувь нь болох 169.0 сая төгрөгийн хэрэг л шүүхэд шилжиж, 107 буюу 71.7 хувь нь болох 401756.7 сая төгрөгийн хэрэг одоог хүртэл шалгагдаж байна.

3.14 Үнийн дүнгээр нь авч үзвэл Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн нийт зөрчлийн дөнгөж 0.04 хувь нь шүүхэд шилжиж, 90.9 хувь нь шалгагдсаар байгаагаас үзвэл үндсэндээ хэргийн шийдвэрлэлт маш хангалтгүй түвшинд байгааг илтгэсэн явдал юм.

3.15 Энэ нь Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд татвар төлөхөөс зайлсхийх асуудлыг тодорхойлсон зүйлчлэл тодорхой бус, цагдаагийн байгууллага болон татварын албаны хооронд ойлголцлын зөрүү байдаг, зарим талаар хэргийн шийдвэрлэлтэд хойрго хандсан, сонирхол бага, хэргийн шийдвэрлэлтэд ажиллаж буй ажилтнуудын мэдлэг чадвар сул байгаатай холбоотой байна.

Шүүхэд шилжүүлсэн иргэний хэргийн 24.2 хувь буюу 46 хэрэгт холбогдох 267.4 тэрбум төгрөг, нийт зөрчлийн 57.0 хувь нь он дамжин хянагдаж байна

3.16 Татварын байгууллагаас 2010, 2011 он, 2012 оны эхний хагас жилийн байдлаар Иргэний хэргийн шүүхэд 797 хэрэгт холбогдох 42,514.2 сая төгрөгийн маргааныг

шийдвэрлүүлэхээр хандсанаас 546 хэрэгт холбогдох 25,194.5 сая төгрөгийн маргааныг шийдвэрлэснээс тоогоор 479 буюу 87.7 хувь, мөнгөн дүнгээр 21,385.1 сая төгрөг буюу 84.9 хувийг төлүүлэхээр шийдвэрлэж үлдсэн нь хүчингүй болжээ.

3.17 Мөн шүүхэд шилжүүлсэн нийт хэргийн 31.4 хувь буюу 251 хэрэгт холбогдох 17.3 тэрбум төгрөг буюу 40.7 хувь нь шүүхийн байгууллага дээр хянагдаж байна. Шүүх дээр хянагдаж буй хэргийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3.2			
Тайлан хугацаа	Хэргийн тоо	Хэргийн дүн	Дундаж Дүн
2010 оны эцэст	100	7 236.2	72.4
2011 оны эцэст	76	7 239.5	95.3
2012 оны хагаст	75	2 844.0	37.9
Нийт	251	17 319.7	69.0

3.18 Шүүхэд шилжүүлсэн иргэний хэргийн 24.2 хувь буюу 46 хэрэгт холбогдох 267.4 тэрбум төгрөг буюу нийт дүнгийн 57.0 хувь нь шүүхийн шатанд хянагдаж байна.

3.19 Дээрх хугацаанд Захиргааны хэргийн шүүхэд 190 хэрэгт холбогдох 469.4 тэрбум

Хүснэгт 3.3			
Тайлант хугацаа	Хэргийн тоо	Хэргийн дүн	Дундаж дүн
2010 оны эцэст	20	16 444.8	822.2
2011 оны эцэст	13	162 772.6	12,520.9
2012 оны хагаст	13	88 141.4	6,780.1
Нийт	46	267 358.8	5,812.1

Гүйцэтгэлийн журмаар хийгдэж буй өрийн барагдуулалт хангалтгүй байна

3.20 Шүүхээс шийдвэр гарч ШШГА-нд гүйцэтгэл хийлгэх татварын өрийн хэмжээ жил тутам нэмэгдэж байна.

3.21 Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэж буй татварын өрийн судалгааг үзүүлбэл:

Хүснэгт 3.4							/сая төгрөг/
Д.д	Он	Оны эхний үлдэгдэл	Тайлант онд нэмэгдсэн	Тайлант онд төсөвт орсон	Хэрэгсэхгүй хүчингүй болсон	Оны эцсийн үлдэгдэл	Татвар төлөгчийн тоо
1	2009	6 206.8	19 268.8	472.1	150.3	25 000.5	214
2	2010	25 000.5	13 128.8	5 146.2	1 964.6	31 018.5	161
3	2011	31,018.5	11 679.4	4 754.6	1 699.8	36 243.5	167
4	2012.11.25	36 243.5	6 742.9	8 031.4	456.9	34 955.0	167

3.22 2008 онд "Татварын өршөөлийн тухай хууль" батлагдсанаар ШШГА-нд шилжсэн 7,538.0 сая төгрөгийн татварын авлага хасагдсан боловч төлүүлсэн дүнгийн эзлэх хувь бага байгаагаас жил тутам өсчээ.

3.23 ШШГА-наас гүйцэтгэл хийгдсэн татварын өр барагдуулалтын 2010, 2011 болон 2012 оны сүүлийн мэдээллээс үзэхэд тухайн тайлант хугацаа тус бүрт 5146.2, 4754.6, 8031.4 сая төгрөгийг төлүүлсэн байна.

3.24 Шийдвэр гүйцэтгэлийн журмаар төлүүлсэн төлбөрийн дүнгийн тухайн тайлант хугацааны төвлөрүүлсэн нийт татварын орлогын гүйцэтгэлийн дүнд эзлэх хувийн жинг авч үзвэл 2010 онд 0.4, 2011 онд 0.3, 2012 оны 9 дүгээр сарын эцсийн байдлаар 0.6 хувийг тус тус эзэлж байна.

3.25 Хэдийгээр тухайн барагдуулалтын дүн бага мэт боловч тайлант хугацааны эхэн дэх өрийн үлдэгдлийн 21.0, 15.3, 22.2 хувийг тус бүр эзэлж байгаа нь өр төлүүлэх ажлыг эрчимжүүлэх, санхүүгийн бусад арга хэлбэрийг нэвтрүүлэх, алдагдсан боломж, мөнгөний өнөөгийн үнэ цэнийг тооцдог байх шаардлагатайг илтгэж байна.

3.26 ҮТА-наас гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа татварын авлагыг бууруулахаар ШШГА-тай хамтран тодорхой ажлуудыг хийж байгаа боловч төдийлэн үр дүнд хүрэхгүй байна.

Дотоод аудит, хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтсийн чиг үүрэг зөвхөн үнэлгээ өгөхөөр л хязгаарлагдаж байна

3.27 Татварын хяналт шалгалтын ажлыг сайжруулах нэг гол асуудал нь давхар хяналтын тогтолцоо бөгөөд ҮТА-ны хувьд энэхүү тогтолцоо хангалттай үйлчлэхгүй байна. Татварын хяналт шалгалтын ажилд хяналт тавих нэг гол нэгж нь ДАХШҮХ бөгөөд ТЕГ-ын энэхүү нэгж 2011 оны 11 сард шинэчилсэн зохион байгуулалтад орж байгуулагдсан байна.

3.28 ДАХШҮХ өнөөдрийн байдлаар хэлтэс, албадын үйл ажиллагаанд мониторинг, үнэлгээ хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид татварын байцаагч, албадын үйл ажиллагаанд давхар хяналт хийж байх зайлшгүй шаардлагатай байна.

3.29 Тухайлбал, 2009-2011 онуудад аймаг, нийслэл, дүүргийн татварын хэлтсүүдээс 9 ААН-ийн үйл ажиллагаанд шалгалт хийж 997.2 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 119.9 сая төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэсэнд ТХШАЗХ-ээс “нягтлах шалгалт” хийхэд 5 ААН-д нэмж 3,497.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 2 ААН-ийн 1,578.5 сая төгрөгийн зөрчилд дүгнэлт бичин УМБГ-т шилжүүлсэн ба 4 ААН-ээс 157.6 сая төгрөг төлүүлэхээр акт бичсэн байна.

3.30 Цаашид дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, татварын хяналт шалгалтын давхар хяналтын тогтолцоог бий болгох, эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна.

Ярилцлагын хэсгээсУБ., 2012

Хууль хяналтын байгууллагаас өнгөрсөн 10 жилийн турш эрүүгийн хэрэг биш гээд шийдвэрлээд байсан байлаа гэхэд хуулийн дагуу төлөх ёстой байсан татварыг нь нөхөн ногдуулаад татварын хуулиар хариуцлага хүлээлгэх явдлыг хяналт шалгалтын нэгж хангалтгүй гүйцэтгэсэн байдаг. Эрүүгийн хуулийн 166 зүйлд анхаарлаа хандуулах юм бол “их хэмжээний орлого” гэсэн нэр томъёо байдаг бөгөөд үүнийг Улсын дээд шүүхээс тайлбарлах боломжгүй гэсэн хариуг татварын албанд удаа дараа өгсөн байдаг. Иймээс хуулинд нь хууль тогтоогч нараар тайлбарлуулахаар Засгийн газраас УИХ-д өргөн барьсан байна. Гэтэл энэ асуудал өмнөх жилүүдэд тодорхой бус байснаас цагдаа, прокурорын байгууллагын зарим албан тушаалтнууд Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйл “Хохирлын хэмжээг тодорхойлох” гэсэн зүйлээр, Эрүүгийн хуулийн 166 зүйлийн “Их хэмжээний орлого” гэдгээр тодорхойлох, ийнхүү хуулийг хэрэглэхийг татварын албанаас шаарддаг, ажилд нь хөндлөнгөөс оролцож зааварчилдаг асуудал өнөөг хүртэл салахгүй байсаар байна.

3.31 Дээр дурдсан тоо, дүн мэдээ, ажлын арга барилаас харахад цаашид үйл ажиллагаандаа зарим өөрчлөлт хийх шаардлагатай байна. Тухайлбал хүний нөөцийн 30 хувийг хяналт шалгалтад ажиллуулж нийт татварын орлогын 1.3 хувийг олох гэж ажиллах бус харин хяналтын байцаагчдын нилээдийг өөр нэгж рүү шилжүүлж, татварын тайлан авах, түүний үнэн зөвд шинжилгээ, дүгнэлт хийх, хэрэв татвар төлөгч

татвараа буруу тодорхойлж тайлангаа гаргасан бол тайлант үеийн ногдлыг засуулах, шаардлагатай тохиолдолд актаар хариуцлага хүлээлгэдэг горим руу шилжих нь зүйтэй байна.

3.32 Харин татвараа төлөхгүй зайлсхийж байгаа хэсэг рүү, ялангуяа том татвар төлөгчид рүү хяналт шалгалтыг чиглүүлбэл бага нөөцөөр үр нөлөөтэй ажиллах бололцоо байна.

3.33 Цөөн хүний нөөцийг ашиглаж үр дүнтэй ажиллаж болох сайн туршлага татварын албанд өөрт нь байгаа бөгөөд 1300 гаруй байцаагчийн дотор 50 орчим хуульч ажилладаг ба нийт татварын албаны хэмжээнд захиргаа, иргэний шүүх дээр шийдвэрлүүлсэн хэргийнхээ 75-аас дээш хувийг татварын албаны талд шийдвэрлүүлж ажилласан байдаг. Энэ нь хүний тоондоо бус ажлыг зөв зохистой сайн зохион байгуулсантай холбоотой гэж дүгнэж болохоор байна.

3.34 УТОХГ-ын хариуцаж байгаа татвар төлөгчдийн татварын өрийн үлдэгдлийг авч үзвэл 2008 оноос 2011 он хүртэл нийт татвар төлөгчийн тоо болон өрийн хэмжээ өссөн байна. Мөн 2012 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар бүртгэгдсэн татвар төлөгчийн тоо болон өрийн хэмжээ зарим татварын төрлөөр буурсан ч уул уурхайн тусгай татварын өр өмнөх 2011 оны үлдэгдлээс өссөн байна.

Хүснэгт 3.5

/тэрбум төгрөг/

Татварын төрөл	2008 он		2009 он		2010 он		2011 он		2012 оны 9 сар	
	ТТ-ийн тоо	Өрийн үлдэгдэл	ТТ-ийн тоо	Өрийн үлдэгдэл	ТТ-ийн тоо	Өрийн үлдэгдэл	ТТ-ийн тоо	Өрийн үлдэгдэл	ТТ-ийн тоо	Өрийн үлдэгдэл
ААНОАТ	81	9.3	88	55.7	72	77.5	115	92.9	17	13.7
НӨАТ	66	12.9	63	10.4	76	32.1	114	29.2	29	16.1
ОАТ	7	4.7	6	6.1	15	3.8	10	6.5	5	0.8
Уул уурхайн тусгай татвар	7	72.0	6	102.1	6	125.9	32	50.0	10	69.6
Бусад	17	91.9	21	17.0	23	12.2	55	79.0	31	16.4
Нийт	177	190.8	184	191.3	192	251.5	386	257.6	92	116.6

Ногдуулалтын хяналтыг эхлүүлжээ

3.35 ТЕГ 2012 оны 5 сараас ногдуулалтын хяналтыг эхлүүлсэн нь үр дүнтэй ажил болсон бөгөөд 2012 оны 10 дугаар сарын байдлаар 18.3 тэрбум төгрөгийн нөхөн ногдуулалт хийж, 34 татвар төлөгчтэй холбоотой 10.6 тэрбум төгрөгийн дүн бүхий зөрчлийг хяналт шалгалтын ажил эрхэлсэн нэгжид шилжүүлжээ.

3.36 Нөхөн ногдуулсан татварын 95.9 хувь нь зөвхөн УТОХГ, нийслэл, дүүргийн хариуцсан татвар төлөгчидтэй холбоотой байна. /Хавсралт №7/

ААНОАТ-ын тухай хуульд оруулсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох тухай өөрчлөлтийн дүнд 2010, 2011 онуудад нийт 60.2 тэрбум төгрөгийн орлогод ногдох татварыг хөнгөлжээ

3.37 2010, 2011 онд өмнөх жилүүдийн татварын тайлангаар гарсан татварын албанаас баталгаажуулсан алдагдлаас тайлант хугацаанд нийт 60.2 тэрбум төгрөгийн алдагдлыг шилжүүлэн тооцсон байна. /Хүснэгт №3.6-д үзүүлэв/

Хүснэгт 3.6

Үзүүлэлт	Он	Дүн /сая төгрөг/	Татвар төлөгчдийн тоо
Өмнөх жилүүдийн татварын тайлангаар гарсан татварын албаны баталгаажуулсан алдагдлаас тайлант хугацаанд шилжүүлсэн дүн	2010	28 690.2	308
		Үүнээс: УТОХГ	
	УТОХГ-ын хувь	12 612.3	16
		44.0	5.2
	2011	31 462.0	171
		Үүнээс: УТОХГ	
УТОХГ-ын хувь	20 484.4	15	
	65.1	8.8	
Нийт		60 152.1	479

3.38 УТОХГ-аас 2012 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 17 ААН-ийн алдагдлын тайланг баталгаажуулж 30,5 тэрбум төгрөгөөр алдагдлыг бууруулж 31,3 тэрбум төгрөгийн алдагдлыг ирээдүйд тооцохоор, 2011 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 10 ААН-ын алдагдлын тайланг баталгаажуулж 3.4 тэрбум төгрөгөөр алдагдлыг бууруулж, 18.2 тэрбум төгрөгийн алдагдлыг ирээдүйд тооцохоор баталгаажуулсан байна.

3.39 Үүнээс үзэхэд алдагдлыг ирээдүйд тооцох энэхүү заалт нь томоохон ААН-үүдийн хувьд илүү хөнгөлөлт эдлэх бололцоог бий болгож байгаа ба түүн дотроо уул уурхайн компаниудад илүү боломжийг бий болгож байна.

3.40 Тухайлбал, Төрийн банкны ААНОАТ-ын төлөлтийг хянаж үзэхэд 2010 онд 1167.2 сая төгрөгийн, 2011 онд 4432.3 сая төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд 2009 оны 4451.4 сая төгрөгийн алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцож 2011 онд ААНОАТ-т 208.8 сая төгрөг л төлжээ.

3.41 Хуулийн дагуу алдагдлыг ирээдүйд шилжүүлсэн тооцсоноор ААНОАТ-аас чөлөөлөгдөж байгаа боловч Сангийн сайдын 2011 оны 2/3074, 2012 оны 2/2352 тоот саналын дагуу Төрийн банкны ТУЗ-ын тогтоолоор 2010 оны цэвэр ашгаас 466.9 сая төгрөг, 2011 оны цэвэр ашгаас 1,329.7 сая төгрөгийг Нийгмийн хөгжлийн санд, Төрийн өмчийн ногдолд 886.4 сая төгрөг хуваарилсан байна.

3.42 Нийгмийн хөгжлийн сангаас ажилтнуудын нийгмийн асуудал, сургалт, шагнал урамшууллыг шийдэж байгаагаас гадна ТУЗ-ын гишүүдийн өргөдлийн дагуу доорх нэр бүхий гишүүдэд орон сууцны дэмжлэг үзүүлжээ. /Хүснэгт 3.7-г харна уу/

3.43 Төрийн банкны ажиллагсад зориулан хуваарилсан Нийгмийн хөгжлийн сангаас ТУЗ-ийн гишүүдэд орон сууцны дэмжлэг олгосон нь Төрийн банк ХХК-ийн дүрмээр зохицуулагдаж болох хэдий ч энэ нь “Компанийн тухай хууль”-иар тодорхойлсон хувь нийлүүлэгчид болон ТУЗ-ийн бүрэн эрхийн холбогдох заалттай зөрчилдөж байна.

			Хүснэгт 3.7
№	Нэрс	Олгосон /сая төгрөг/	Албан тушаал
1	Б.Ганбат	90,0	ТУЗ-ын гишүүн
2	Б.Гэрэлмаа	90,0	ТУЗ-ын гишүүн
3	Л.Ганбат	90,0	ТУЗ-ын гишүүн
4	Л.Зоригт	90,0	ТУЗ-ын гишүүн
5	Б.Батбаяр	90,0	ТУЗ-ын гишүүн
6	Г.Баясгалан	90,0	ТУЗ-ын гишүүн
	Нийт	540,0	

3.44 Мөн банкны дүрэм, Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний хүрээнд ТУЗ, Хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлагад урамшуулал олгож байгаа боловч ТУЗ-өөс

явуулж буй үйл ажиллагаа нь "Нийтийн албанд нийтийн болон хувийн эрх ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуультай зөрчилдөж байна.

3.45 Иймд компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээг компанийн тухай хуультай нийцүүлэх шаардлагатай байна.

Татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай хэлэлцээрийг бүхэлд нь хянаж үзэх нь зүйтэй

3.46 Өнөөдрийн байдлаар манай улс “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”-ийг нийт 35 улстай байгуулж, үүнээс 30 нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа талаар ТЕГ-аас тайлагнажээ. /Хавсралт №8/

Манай улсын хуулиар тухайн гол төрлийн татварын суутган тооцох хувь хэмжээг тус бүрт 20 хүртэл хувиар ногдуулж байхаар хуульчилсан. Гэтэл татвар төлөгчийн бүх төрлийн хүүгийн орлогод татвар ногдуулахгүй байх, эрхийн шимтгэлийн орлогод 5-10 хувиар, манай улсын аливаа эх үүсвэрээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогод 0-5 хувиар тооцохоор байгаа ч уг бүртгэлтэй нэгжүүдээс хичнээн хэмжээний татварыг төвлөрүүлсэн талаарх тоон мэдээлэл алга байна. Түүнчлэн бусад улсуудын давхар гэрээний нөхцөлтэй харьцуулахад ч үр ашиг муутайг анхаарвал зохилтой юм.¹⁹

3.47 Гэвч энэ төрлийн гэрээ хэлэлцээр эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадны хөрөнгө оруулалтыг хуулиар баталгаажуулж дэмжсэн бодлогын чанартай асуудал мэт боловч үндсэндээ татварын орчны хувьд улсын эрх ашигт төдийлөн нийцдэггүй байна.

3.48 Хэлэлцээртэй улс орнуудад бүртгэлтэй ААН-үүдээс сүүлийн жилүүдэд оруулсан хөрөнгө оруулалтын талаарх дорвитой судалгаа хийгдээгүй, үр нөлөөг тооцоогүй байна.

3.49 Харин манай улсад үйлчилж буй татварын хувь хэмжээг "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай" хэлэлцээртэй орнууд болон бусад улсуудад мөрдөж буй татварын /ААНОАТ, НӨАТ/ хувь хэмжээтэй харьцуулахад доогуур түвшинд, ХХОАТ-ын хувьд тухайн улс орнуудад олон шатлалт хувь хэмжээг мөрдөж байна. /Хавсралт №8.1/

3.50 ДНБ-д эзлэх татварын орлогын хэмжээг бусад орнуудтай харьцуулахад дунджаас дээгүүр түвшинд байна. /Хавсралт №8.2/

3.51 Иймд хэлэлцээртэй улс болон хөрш орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээрийн заалт бүрийг дахин нягтлах, үр нөлөөг үнэлэх, цаашдаа давхар татварын гэрээ, хэлэлцээрийг улсын эрх ашигт нийцүүлэн бүхэлд нь хянан үзэх шаардлагатай байна.

3.52 Түүнчлэн Оффшор²⁰ бүсэд буюу тэдгээр улсуудад бүртгэлтэй компаниуд гадаадын зах зээлээс олсон орлогоосоо төлдөггүйн зэрэгцээ ихэнх тохиолдолд тухайн бүртгэлтэй улсынхаа газар нутаг дээр бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд

¹⁹ Эх сурвалж: <http://www.iltod.gov.mn/> “Монгол Улсаас бусад улс оронтой байгуулсан давхар татварын гэрээ хэлцлүүдийг НҮБ, ЭЗХАХБ-ын давхар татварын гэрээний загварууд, мөн манай улстай хөгжлийн түвшин ойролцоо буюу доогуур зарим улсын (Филиппин, Гана) давхар татварын гэрээтэй харьцуулж үзэхэд, манай улсын хувьд үр ашиг, давуу тал багатай гэрээнүүд хийгдсэн байна”

²⁰ “Off-shore” хэмээх англи үг нь эргийн цаадах, эргийн гаднах гэсэн утга илэрхийлдэг бол харин “tax heaven” нь татваргүй орчин буюу татварын диваажин гэсэн утгатай.

УТОХГ-ын хариуцаж буй том татвар төлөгч нэгжүүдээс ч энэхүү бүс, улс оронд бүртгэлтэй байдгийг анхаарах нь зүйтэй.

Гадаад, дотоод худалдаа хөрөнгө оруулалтын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын нягтлан бодогчтой хийсэн ярилцлагын хэсгээсУБ., 2012

Оршин суугч бусын суутгал 20%, дээр нь нэмэгдэж байгаа оршин суугч бус этгээдээс суутгах НӨАТ-ын 10% нь амьдрал дээр тухайн оршин суугч бус этгээдүүд 20-30% суутгуулдаггүй, тухайн үйлчилгээ, зөвлөх авсан монгол компаниуд нэмж төлж байна. Иймд эргээд 30-50 %-ийн нэмэгдэлтэй татварын дарамт болж байна. Үүнийг ядаж НӨАТ тооцдогийг болиулах хэрэгтэй. Мөн давхар татварын гэрээ нь ойлгомжгүй, хэрэгжүүлэх арга зам зааварчилгаа байдаггүй. Өөрөөр хэлбэл мэргэжлийн нилээн сайн хуульч ойлгохоос энгийн нягтлан бодогч, захирал ойлгох хялбар гарын авлага байхгүй тул төлөх ёсгүй татвараа төлөх, түүнийг хэлж өгөх татварын байцаагч нарын ихэнх нь энэ талын мэдлэг хомс байдаг. Гэтэл ойлгомжтой зарим зүйл заалтыг зарим нэг компаниуд илүү сайн ашиглаж бүр татвараас зугтаадаг. Жишээ нь: Голланд, Люксембург, Англи, Швейцарь улсаас хөрөнгө оруулсан нэрээр ногдол ашгийн 10%-ийн татвараас 100% чөлөөлөгдөх, эсвэл 50 %-иар чөлөөлөгдөж байна. Гэтэл хувь нийлүүлэгчид, өөрийн компани дээрээ 10%, өөртөө хүлээж авахад 10% ногдол ашгийн татвар төлөхөөр байна. Тэгэхээр татварын хувьд тэгш зарчим үйлчлэх шаардлагатай байна.

Далд эдийн засагтай тэмцэх үйл ажиллагааг дэмжих нь зүйтэй

3.53 Банкнаас гадуурх мөнгө 2010 онд 388.2 тэрбум, 2011 онд 517.5 тэрбум, 2012 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 591.3 тэрбум төгрөг байна.²¹

График 3.4



3.54 Татвараас зайлсхийхтэй тэмцэж буй өнөөгийн хэлбэрийг татварын албаны ажилтнууд өөрсдөө хэрхэн үнэлж дүгнэж байгаагаас үзэхэд төр, засгийн дэмжлэг илүүтэй шаардагдаж буйг 56.9 хувь тэмдэглэсэн байна.

/График 3.4-ийг харна уу/

3.55 Далд эдийн засгийг илрүүлэх, бууруулахад хууль эрх зүйн орчны өөрчлөлт, татвар, мөнгөн гүйлгээ, бүртгэл хяналт чухал үүрэгтэй. /График 3.5, 3.6-г харна уу/

График 3.5

Нуугдмал болон далд эдийн засгийг илрүүлж татварыг бүрэн хэмжээгээр авч чадаж байна уу?





График 3.6

Нуугдмал орлого хаана илүү байна гэж Та боддог вэ?



²¹ Эх сурвалж: Монголбанкнаас гаргасан "Мөнгөний статистикийн тойм", Үндэсний статистикийн хороо, Статистикийн эмхтгэл

3.56 Түүнчлэн нуугдмал орлого татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн аль алинд нь байгаа ба ААН-ийн хувьд татвар хамрагдалт харьцангуй өндөр хувьтай, харин хувь хүний бизнесийн татварыг бүрэн хамруулж чадахгүй байна гэж үзжээ.

3.57 Судалгааны дүнгээс үзэхэд татварын орлогыг бүрэн хэмжээгээр авч чаддаггүй гэж үзсэн бөгөөд нийт төвлөрүүлж буй орлоготой дүйцүүлэн жишихэд бараг 1/3-ийг авч чадаагүй гэж дүгнэж болохоор байна.

Жишиг үнэ тогтоох, түүнийг мөрдөхөд нэгдсэн ойлголт, аргачлалтай байх нь зүйтэй

3.58 Эрдэс баялаг, эрчим хүчний яам/хуучин нэрээр/-наас 2011 оны 8, 9, 10 дугаар сарууд болон 2012 оны эхний хагаст төмрийн хүдэр болон баяжмалын дэлхийн зах зээлийн жишиг үнийг утга, агуулгын хувьд зөрчилтэй, ойлгомжгүй байдлаар зарлаж, хэд хэдэн удаа өөрчилсөн нь АМНАТ-ын тооцооллыг хийхэд хүндрэл учруулж байна.²²

3.59 Иймд Уул уурхайн /ЗГ-ын шинэчилсэн бүтэц/ болон Сангийн яамнаас хуулийн хүрээнд²³ ойлголцлын зөрүүтэй байдлыг арилгах, нэгдсэн нэг заавар аргачлалтай болох шаардлагатай байна.

²² Эх сурвалж: ТЕГ-ын УТОХГ-ын ТТХХ-ээс гаргасан тайлбар

²³ Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6, 47.8 дугаар зүйл

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Татварын ерөнхий газар 2009 оноос хойш жил бүр бүтцийн өөрчлөлт хийж шинээр бүтцийн нэгжүүд бий болгож, орон тоог нэмэгдүүлсэн байна. Ингэхдээ хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон судалгаагүй, стратеги төлөвлөгөөнд тулгуурлаагүйгээс шинэ нэгжүүдийн чиг үүрэг тодорхойлогдож баталгаажаагүй, чиг үүргийн давхардал бий болсон, батлагдсан хязгаараас илүү тоогоор ажиллахад хүргэсэн байна.
- Үндэсний татварын албаны хуулиар хүлээсэн чиг үүрэг, ажлын ачааллыг хөнгөвчлөхөд олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг нэвтрүүлэх чиглэлээр ТЕГ судалгаа дүгнэлт хийж, үйл ажиллагаагаа боловсронгуй болгох бодлого баримталж ажиллаагүй байна.
- Татвар төлөгчдийн тоо өсөхийн зэрэгцээ “Х” болон “алдагдалтай” тайлангийн эзлэх хувь хэмжээ өсөх, татварын албадын үр ашигт байдлын түвшний үзүүлэлт буурах хандлага гарч байгаа нь татварын болон бизнесийн орчинг сайжруулахаас гадна татвар төлөгчдөд чиглэсэн уламжлагдсан, татвараас зайлсхийх сэтгэл зүйд хүрч ажиллах үйлчилгээ дутагдалтай байна.
- 2012 онд улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөө 240.0 гаруй тэрбум төгрөгөөр тасалдахад хүрсэн нь эдийн засгийн гадаад орчны нөлөөлөл байгаагаас гадна татварын орлогын төлөвлөлт үндэслэл муутай, эрсдлийг бүрэн тооцдоггүй, асуудлыг хариуцсан нэгжүүд чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байгаатай холбоотой байна.
- Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтэд илүү дайчилсан татвар болон урьдчилгаа төлбөр багагүй хувийг эзлэх болсон нь цаашид татвар төлөгчдөд дарамт учруулах, улсын төсвийн орлогын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөхөөр байна. Дээрх байдалд орлогын төлөвлөгөөний биелэлт болон давуулсан орлогод урамшуулал олгодог тогтолцоо нөлөөлж байгааг анхаарах шаардлагатай.
- Зарим татварын албадын үйл ажиллагаагаа явуулах, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний хэвийн нөхцлийг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлж, үр дүнг сайжруулах шаардлагатай байна.
- Төлөвлөгөөт шалгалтын үр дүн нь бүрэн болон сэдэвчилсэн шалгалтын үр дүнгээс бага, ногдуулалтын хяналтаар нөхөн ногдуулсан татварын 95.9 хувь нь том татвар төлөгчидтэй холбоотой, МТЗ-өөр хэлэлцэгдсэн татварын өрийн 86.2 хувийг хүчингүй болгосон зэргээс үзэхэд татварын хяналтын бодлого, үйл ажиллагаанд өөрчлөлт хийх шаардлагатай болсныг харуулж байна.
- Цагдаа, прокурорын байгууллагад өгсөн хэргийн 0.03 хувь шүүхэд шилжсэн, шүүхэд шилжүүлсэн иргэний хэргийн 24.2 хувь, нийт зөрчлийн 57.0 хувь он дамжин хянагдах зэргээр татварын маргаантай асуудал хэрэгсэхгүй болох, хэргийн шийдвэрлэлт удаан байна.
- Татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай олон улстай байгуулсан хэлэлцээрийг бүхэлд нь дахин хянаж үзэж, төрийн бодлого, шаардлагад нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.
- Төрийн банкны ХХК-ний Нийгмийн хөгжлийн сангаас ТУЗ-ийн гишүүдэд бүгд 540.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг олгосон байна.

1. Сангийн яамнаас ирүүлсэн санал:



15100 Увсанбувсар хөш, Чингэлтэй дүүрэг,
С.Дансандоржийн гудамж, Засагийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 25-02-47, И-мэйл: www.1101.gov.mn

2012.01.16 № 4-2/254
таны _____ -ны № _____ -т

Санал өгөх тухай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
А.ЗАНГАДТАНАА

УИХ-ын Төсвийн байнгын хорооны саналаар “Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

**Тайлбар
1.1-ийг
үзнэ үү.**

1. Гүйцэтгэлийн аудитын тайлангийн 1.2-т Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн оорчлолтийн хөтөлбөрийг Сангийн яаманд 3 удаа ирүүлсэн ч тодорхойгүй налтгаанаар хойшилсон гэсэн байна. Эгч асуудлаар Сангийн яаманд урьд нь хандаагүй бөгөөд зөвхөн татварын албаны бүтэц, орон тооны асуудлыг хөндөж, тухай бүр асуудлыг шийдвэрлэсэн баримт үлдсэн байна.

**Тайлбар
1.2-ыг
үзнэ үү.**

2. Тайлангийн 2.5-д улсын төсөвг 2010-2012 онд төвлөрүүлэх татварын орлогын санал, өргөн барьсан санал болон батлагдсан төсвийг хүснэгтээр үзүүдсэн байна. Татварын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д зааснаар татварын шилб нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар тодогчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй. Харин Сангийн яам нь тухайн жилийн төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжт эх үүсвэрийг бүрэн дайчлах, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилгыг биелүүлэх, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлэх, татвар хураалтыг эрчимжүүлэх, төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг жигд хэрэгжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх зарчмыг баримтлан Монгол Улсын тухайн жилийн макро эдийн засгийн үзүүлэлт, өмнөх жилүүдийн гүйцэтгэл, татварын тайлангаар гарсан урьдчилсан ногдуулалт, татварын илүү төлөлтөд үндэслэн татварын орлогын төлөвлөгөөг боловсруулж байна. Иймд Татварын Ерөнхий Газар орлого төлөвлөх эрх үүрэгтэй тул тайлангийн 2.5-аас хойш дээрх дурьдсан асуудалтай холбоотой хэсгийг хасах саналтай байна.

**Тайлбар
1.3-ыг
үзнэ үү.**

Тайлангийн 2.18-д тайлант хугацааны ногдлын хэмжээг төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 2010-2012 оны 10 сар хүртэл 56.7-92.6 хувь, хураалтын түвшинтэй харьцуулахад 50.9-98.9 хувийг эзэлж байна гэж дүгнэсэн байна. Хүснэгтийг татварын албаны мэдээллийн баазын нэгтгэлтэй тулган үзвэл татварын ногдлыг илт дутуу тооцож, дүгнэлт гаргасан байна. Тухайлбал, 2011 оны жилийн эцсийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар аж ахуйн нэгжийн татварын тайлангийн ногдол 627.0 тэрбум төгрөг байна. Гэтэл тус хүснэгтэд 443.4 тэрбум төгрөгийн татварын ногдолтой гэж ташаа мэдээлсэн байна.

2012.01.16

Иймд татварын ногдол, тоологөөтэй харьцуулсан 2.15-2.29 хүртэлх дүгнэлт, зөвлөмжийг хасах саналтай байна.

Тайлбар 1.4-ийг үзнэ үү.

4. Тайлангийн 2.30, 2.31-д 2011 онд Засгийн газар “Оюу толгой” ХХК болон “Эрдэнэс МГЛ” ХХК-иас урьдчилгаа төлбөр авсан нь татварын орлогын төлөвлөгөө биелэхгүй байх шалтгаан болсон гэж дүгнэжээ. Гэтэл тус гэрээний дагуу авсан урьдчилгаа толбөр нь өмнөх жилүүдэд татварын орлогоор бүртгэгдээгүй, татварын ногдол гарсан үед нь олон улсын стандартын дагуу татварын орлогоор бүртгэх ёстой бөгөөд 2012 оноос эхлэн тус компаниудын үйл ажиллагааны үр дүнд бий болох албан татварт тооцож, татварын өр төлбөрт суутгасан тул татварын төлөвлөгөөг таслах шалтгаан болохгүй. Иймд уг дүгнэлттэй холбоотой хэсгүүдийг хасах саналтай байна.

Тайлбар 1.5-ыг үзнэ үү.

5. Тайлангийн 3.7-оос хойшхи болон дүгнэлт хэсэгт тусгасан “Маргаан таслах зөвлөл”-ийн талаарх дүгнэлтэд татварын улсын байцаагчдын мэдлэг чадвар сул байгаагаас үүдэн үндэслэлгүй акт тавигдаж байгааг дурьдах нь зүйтэй гэж үзэж байна.

Тайлбар 1.6-г үзнэ үү.

6. Тайлангийн 3.40-өөс хойшхи болон дүгнэлт хэсэгт тусгасан Төрийн банкны нийгмийн асуудал шийдвэрлэсэн талаарх дүгнэлт, санал нь Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүнтэй огт хамааралгүй тул хасах нь зүйтэй байна.

Бусад асуудлаар аудитын дүгнэлтэд санал нэг байгаа бөгөөд цаашид танай зөвлөмжийг ажил хэрэг болгон хэрэгжүүлэх болно.

Хүндэтгэсэн,

САЙД



Ч.УЛААН

2. Татварын ерөнхий газраас ирүүлсэн санал:



Танай газраас ирүүлсэн 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 05 дугаар албан бичиг, “Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-ийн төсөлтэй танилцлаа.

Гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжид тусгуулахаар холбогдох тайлбар, саналыг хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
 ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАТМАГНАЙ

8 211

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ХЭСЭГТ
ТУСГУУЛАХ ТАЙЛБАР, САНАЛ

2013 оны I дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Үндэсний аудитын газраас ТЕГ-ын 2010, 2011 он, 2012 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжид тусгуулахаар дараах тайлбар, саналыг гаргаж байна. Үүнд:

Нэг. Дүгнэлтэд

**Тайлбар
2.1-ийг үзнэ үү.**

«...Үндэсний татварын албаны хуулиар хүлээсэн чиг үүрэг, ажлын ачааллыг хөнгөвчлөхөд олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг нэвтрүүлэх чиглэлээр ТЕГ судалгаа дүгнэлт хийж, үйл ажиллагаагаа боловсронгуй болгох бодлого баримталж ажиллаагүй байна...» дүгнэлтэд:

Хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг өргөтгөх зорилгоор ТЕГ-т “Эрдэмтдийн зөвлөл”, “Бизнесийн зөвлөл”-ийг эрдэмтэд, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулан байгуулж, татварын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлийн талаархи саналыг нэгтгэн хуулиудад оруулах өөрчлөлтийн төсөлд тусгаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлон санал боловсруулж хамтран ажиллав.

ТЕГ-ын даргын 2011 оны 4 сарын 29-ны өдрийн 259 тоот тушаалаар “Эрдэмтдийн зөвлөл”-ийг байгуулан 2012 онд 8 удаа, Бизнесийн зөвлөлийн 3 удаагийн хурал зохион байгуулж, татварын холбогдолтой харилцааг зохицуулж буй эрх зүйн орчинг сайжруулах, боловсронгуй болгох талаар судалгаа явуулж, санал боловсруулах, улс орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, өсөлтийг тэтгэн дэмжихэд татварын үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх санал боловсруулан хэлэлцүүлж хамтран ажилласан. Мэдлэгийн эдийн засаг, инновацийн тогтолцоог бүрдүүлэхэд төрийн байгууллагуудын үүрэг, Эдийн засгийн өсөлтийг татварын бодлогоор дэмжих нь зэрэг сэдвүүдээр уулзалт хэлэлцүүлэг, Бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоог хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, Эрсдлийн удирдлага ба ногдуулалтын хяналт зэрэг сэдвүүдээр зөвлөгөөн зохион байгуулж ажилласан.

Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг өргөтгөх, тэдний татварын хууль тогтоомжийн талаархи болон НББ-ын мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр МАОЭХ, ТИНЗ нийгэмлэг, ММНБИ, АОЭХ, МҮХАҮ-ийн танхим зэрэг газруудтай хамтран ажилласан болно.

**Тайлбар 2.2-ыг
үзнэ үү.**

«...Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтэд илүү дайчилсан татвар болон урьдчилгаа төлбөр багагүй хувийг эзлэх болсон нь цаашид татвар төлөгчдөд дарамт учруулах, улсын төсвийн орлогын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөхөөр байна. Дээрх байдалд орлогын төлөвлөгөөний биелэлт болон давуулсан орлогод урамшуулал олгодог тогтолцоо нөлөөлж байгааг анхаарах шаардлагатай...» дүгнэлтэд:

Татварын ерөнхий газраас улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүд, татвар төлөгчийн тоо, сүүлийн 3-5 жилийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлант оны төлөвлөгөө, хүлээгдэж буй гүйцэтгэлд суурилан татварын төрөл бүрээр холбогдох судалгаа, татвар төлөгчийн саналыг тусган боловсруулж Сангийн яаманд хүргүүлдэг.

Сангийн яам, улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөөний төслийг хянаж, УИХ-аар батлуулах явцад Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөгөлбөрт туссан улс төрийн намуудын амлалтыг хэрэгжүүлэх, улсын төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд шаардлагатай уялдуулсан

**Тайлбар
2.3-ыг
үзнэ үү.**

төсвийн зарлагад суурилан тооцоо судалгаагүйгээр улсын төсвийн орлогын төлөвлөгөөг өсгөж байна.

УИХ-аар улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөө нь хууль болон батлагддаг, санхүүгийн жил тухайн оны 12 сарын 31-нээр дуусдаг бол тухайн төрлийн татварын төлөх тайлагнах эцсийн хугацааг дараа онд хийхээр тухайн төрлийн татварын хуулиар зохицуулагдсан байна.

Дээрхи шалтгаануудаар татвар төлөгчдөөс урьдчилгаа татвар төлүүлж байгаа бөгөөд энэ нь татварын хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж байна.

«...Төлөвлөгөөт шалгалтын үр дүн нь бүрэн болон сэдэвчилсэн шалгалтын үр дүнгээс бага, ногдуулалтын хяналтаар нөхөн ногдуулсан татварын 95.9 хувь нь том татвар төлөгчидтэй холбоотой, МТЗ-өөр хэлэлцэгдсэн татварын өрийн 86.2 хувийг хүчингүй болгосон зэргээс үзэхэд татварын хяналтын бодлого, үйл ажиллагаанд өөрчлөлт хийх шаардлагатай болсныг харуулж байна...» дүгнэлтэд:

ҮТА-ны татварын хяналт шалгалтанд хамруулах татвар төлөгчдийг холбогдох хууль тогтоомж, эрсдлийн үнэлгээ, судалгаа зэргийг үндэслэн сонгож татварын хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө боловсруулан ТЕГ-ын даргаар батлуулдаг бөгөөд уг төлөвлөгөөнд тусгагдсан бүх татвар төлөгчид бүрэн, эсхүл сэдэвчилсэн хяналт шалгалтанд хамрагддаг.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтанд хамруулж буй тухайн татвар төлөгчийн:

Бүрэн хяналт шалгалтанд бүх татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хийх хяналт шалгалт хамрагддаг.

Сэдэвчилсэн хяналт шалгалтанд нэг төрлийн албан татвар, төлбөр, хураамж буюу онцгой, нэмэгдсэн өртөг, буу, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, ашигт малтмалын нооц ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлт, бусад хуулийн хэрэгжилт буюу онцгой албан татварын тэмдгийн ашиглалтын байдал гэх зэргийн хяналт шалгалт хамрагддаг.

Гэтэл «...Төлөвлөгөөт шалгалтын үр дүн нь бүрэн болон сэдэвчилсэн шалгалтын үр дүнгээс бага...» гэж дүгнэсэн нь «татварын хяналтын бодлого, үйл ажиллагаанд ямар өөрчлөлт хийх шаардлагатай болсныг харуулж байгаа...» нь ойлгомжгүй байна.

ТЕГ-ын даргын 2012 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 667 дугаар тушаалаар баталсан «Татварын тайланд ногдуулалтын хяналт хийх журам»-ын дагуу Татварын алба татвар төлөгчөөс хууль тогтоомжийн дагуу ирүүлсэн татварын тайланд орлогоо бүрэн тусгаж, татвараа үнэн зөв тодорхойлсон эсэхэд татвар төлөгчтэй холбоотой хөндлөнгийн мэдээлэл, бусад тайлангийн үзүүлэлт зэргийг ашиглан ногдуулалтын хяналтыг хийж эхэлсэн байхад 2012 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд аудит хийсэн гэх атлаа:

ҮТА-ны хэмжээнд 2012 оны эхний хагас жилд бүрэн хэрэгжиж эхлээгүй үйл ажиллагааг зөрчил мэтээр үзсэн байна.

УТОХГ ногдуулалтын хяналтыг 2012 оны эхний хагас жилд хэрэгжүүлж эхэлсэн, том татвар төлөгчид төсвийн орлогын 86.0-88.0 хувийг бүрдүүлдэг байхад нөхөн ногдуулсан татварын хэмжээ жижиг татвар төлөгчдөөс бага байхгүй нь ойлгомжтой асуудал.

2011-2012 оны эхний хагас жилийн байдлаар шийдвэрлэсэн гомдол маргааныг хүчингүй болгож шийдвэрлэхэд

1. Татварын болон бусад хууль тогтоомжийн хоёрдмол утга санаа агуулсан байдал болон гэрээ хэлэлцээрээр татварын харилцааг зохицуулсан байдал
2. Татварын улсын байцаагчдийн хууль эрх зүйн мэдлэгийн дутмаг байдлаас хууль буруу хэрэглэсэн байдал голчлон нөлөөлсөн байна.

Мөн түүнчлэн 2012 оны 02 сард “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д холбогдох 210098 тоот татварын улсын байцаагчийн актаар ногдуулсан 350,733,254.7 мянган төгрөгийн төлбөрийг Монгол улсын Засгийн газраас Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах тухай хоронго оруулалтын гэрээнд заасан заалтыг үндэслэн бүхэлд нь хүчингүй болгож шийдвэрлэсэн байдал

үнэмлэхүй хэмжээгээр нөлөөлсөн боловч МТЗ-өөр шийдвэрлэгдсэн татварын хэргийн шийдвэрлэлтийг татвар төлөгчийн тоогоор авч үзвэл Татварын албаны хэмжээнд тайлант хугацаанд захиргаа, иргэний шүүхэд татварын албыг төлөөлөн иргэний нэхэмжлэгч, хариуцагчаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн хүрээнд ажиллах талаар татварын албадыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, зарим тохиолдолд төлөөлөн оролцох ажлыг гүйцэтгэж, Захиргааны хэргийн шүүх татварын улсын байцаагчийн 49 акттай холбогдох 341 584 485,8 мянган төгрөгийн зөрчилд ногдох 181 386 164,9 мянган төгрөгийн төлбөрийн татварын маргааныг хянан хэлэлцэж, 97 446 505,3 мянган төгрөг буюу 73,4 хувийг эцэслэн шийдвэрлэсэн байна. Үүнээс 89 753 319,5 мянган төгрөг буюу 93 хувийг татварын алба өөрийн талд шийдвэрлүүлсэн, 7 713 285,8 мянган төгрөг буюу 7 хувийг татвар төлөгчийн талд шийдвэрлэсэн, одоо 83 919 859,6 мянган төгрөг буюу нийт төлбөрийн 26,4 хувь нь шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлэгдээгүй хянагдаж байна.

Иргэний шүүхэд татварын улсын байцаагчийн 264 акттай холбоотой татварын 15 031 129,4 мянган төгрөгийн өрийг нэхэмжилснээс 5 759 796,7 мянган төгрөг буюу 96 хувийг татварын албанд төлүүлхээр, 186 617,5 буюу 4 хувийг татвар төлөгчийн талд хүчингүй болгосон, нийт өрийн 9350615,2 мянган төгрөг эцэслэн шийдвэрлэгдээгүй хянагдаж байна.

Татварын албаны дэргэдэх татварын маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг үнэлэх, дүгнэх ажлыг тухайн татварын албаны дарга Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 42.8-д “Маргаан таслах зөвлөлийн тогтоолыг тухайн шатны татварын албаны дарга тушаал гарган баталгаажуулах бөгөөд нийнхүү баталгаажуулах үндэслэлгүй гэж үзвэл шалтгааныг тодорхой тусгасан тайлбарын хамт Маргаан таслах зөвлөлд буцаана. 42.9. Маргаан таслах зөвлөл энэ хуулийн 42.8-д заасан татварын албаны даргын тайлбарыг хуралдаанаараа хэлэлцэн түүнийг хүлээн зөвшөөрвөл тогтоолоо өөрчлөх ба хэрэв хүлээн зөвшөөрөөгүй бол дээд шатны татварын албаны удирдлагад тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно.

«...Цагдаа, прокурорын байгууллагад өгсөн хэргийн 0,03 хувь шүүхэд шилжсэн, шүүхэд шилжүүлсэн иргэний хэргийн 24,2 хувь, нийт зөрчлийн 57,0 хувь он дамжин хянагдах зэргээр татварын маргаантай асуудал хэрэгсэхгүй болох, хэргийн шийдвэрлэлт удаан байна...» дүгнэлтэд:

Татварын албаны хэмжээнд 2012 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 306,938,894.0 төгрөгийн 42 дүгнэлт бичигдэж цагдаагийн байгууллагад шилжүүлснээс эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 1 /3,332,345.10 төгрөг/, хэрэгсэхгүй болгосон 3 /4,620,635.0 төгрөг/, шалгагдаж байгаа хэрэг 38 /298,985,913.9 төгрөг/, шүүхэд шилжүүлсэн хэрэг байхгүй байна. ТУБ-ийн дүгнэлтийн дагуу шалгагдаж байгаа эрүүгийн хэргийн 90 орчим хувь нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгогдож байгаа нь шинжээчийн дүгнэлтээр зөрчлийн үнийн дүн буурч үүнээс төсөвт төлөх ёстой байсан татварын хэмжээг тооцоход тэр нь хохирлын доод хэмжээнд хүрэхгүй байна гэж үзэн хэргийг хэрэгсэхгүй болгож байна. Нөгөө талаар Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйл /Татвар төлөхөөс зайлсхийх/-ийн заалт нь тодорхой бус байдгаас хууль хяналтын байгууллагууд болон татварын алба хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх асуудал хүндрэл, бэрхшээлтэй байдагтай шууд холбоотой. Эрх зүйн орчныг тодорхой болгох талаар татварын албаны зүгээс тодорхой хуулийн төсөл боловсруулан холбогдох газарт хүргүүлсэн болно.

Татварын маргаантай эрүүгийн хэргийн шийдвэрлэлт удаашралтай байгаа нь татвар төлөгч дүгнэлтэнд гомдол гаргах эрх нь нээлттэй байдаг тул шат шатны Маргаан таслах зөвлөлд гомдол гаргадаг бөгөөд эцсийн шийдвэр гарах хүртэл 6-12 сарын хугацаа шаардагддаг байна. Мөн түүнчлэн татварын маргаантай эрүүгийн хэрэгт тусгай мэдлэг мэргэжил шаардагддаг тул мөрдөн байцаагч шинжээч томилж шинжээчийн дүгнэлт гаргуулах, анх дүгнэлт бичсэн ТУБ-ийг гэрчээр оролцуулах зэрэг ажиллагаанууд зайлшгүй хийгддэг тул хэргийн шийдвэрлэлт удаашралтай байдаг байна.

**Тайлбар
2.4-ийг
үзнэ үү.**

Нийт татварын албаны хэмжээний захиргааны болон иргэний шүүхээр шийдвэрлүүлсэн татварын хэрэг маргааны судлагааг нэгтгэн гаргасан бөгөөд 2012 онд татварын алба нийт 242,514,511.10 мянган төгрөгийн 313 татвар төлөгчтэй холбоотой маргаанд нэхэмжлэгч, хариуцагчаар ажилласан байна. Үүнийг шүүх тус бүрээр авч үзвэл:

Захиргааны шүүхийн хувьд татварын улсын байцаагчийн 49 акттай холбогдох 181 386 315,3 мянган төгрөгийн төлбөр бүхий татварын маргааныг хянан хэлэлцэж, 97 466 549,5 мянган төгрөгийг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн байна. Эцэслэн шийдвэрлүүлсэний 89 753 319,5 мянган төгрөг буюу 93 хувийг татварын албаны талд төлүүлэхээр, 7 713 285,8 мянган төгрөг буюу 7 хувийг татвар төлөгчийн талд хүчингүй болгохоор тус тус шийдвэрлэж, одоо 83 919 759,6 мянган төгрөг буюу нийт төлбөрийн 46,2 хувь нь шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлэгдээгүй хянагдаж байна.

Иргэний шүүхийн хувьд татварын улсын байцаагчийн 264 акттай холбоотой татварын 15 031 129,4 мянган төгрөгийн төлбөр бүхий татварын маргааныг хянан хэлэлцэж, 5945 841,1 мянган төгрөгийн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн байна. Эцэслэн шийдвэрлүүлсэний 5 759 796,7 мянган төгрөг буюу 96 хувийг татварын албаны талд төлүүлэхээр, 186 125,5 мянган төгрөг буюу 4 хувийг татвар төлөгчийн талд хүчингүй болгохоор тус тус шийдвэрлэж, одоо 9 350 715,2 мянган төгрөг буюу нийт төлбөрийн 62,2 хувь нь шүүх дээр хянагдаж байгаа.

Татварын алба Шүүхэд хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульд заасан эрх, үүргийн хүрээнд, хэргийн оролцогчийн байр сууринаас оролцдог бөгөөд Шүүх эрх мэдлийн байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх хуулийн хугацаанд хөндлөнгөөс нөлөөлөх эрхгүй болно.

Хоёр. Зөвлөмжид:

Тайлбар 2.5-ыг үзнэ үү.

«...Нийслэл, дүүргийн төсвөөс урамшуулалд авч, ашигласан мөнгөн хөрөнгийн хөдлөл, үр дүнг УТА-ны санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэн тайлагнаж байх...» зөвлөмжид:

Татварын ерөнхий газар нь улсын төсвөөс авсан санхүүжилт, төсвийн зарцуулалтыг санхүүгийн нэгдсэн тайландаа тусгадаг. Орон нутгийн татварын албадад тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээгээр олгогдож буй үр дүнгийн урамшуулал, түүний зарцуулалт нь тухайн орон нутгийн төсөв захирагчийн санхүүгийн тайланд тусгагдаж, орон нутгийн ИТХ-аар хянагддаг болно. Иймд гэрээний дагуу урамшуулалд авч, зарцуулсан мөнгөн хөрөнгийн хөдлөл, үр дүнг УТА-ны санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэн тусгах боломжгүй байна.

Тайлбар 2.6-г үзнэ үү.

«...Татвараас зайлсхийхтэй тэмцэж буй ажлын үр нөлөөг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх...» зөвлөмжид:

УТА далд эдийн засгийг ил болгох, татвараас зайлсхийх үйлдлийг илрүүлэн татварт хамруулах, татварын хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах, хяналт шалгалтын ажил эрхэлсэн Татварын улсын (ахлах) байцаагчдын мэдлэг мэргэшил, үр чадварыг дээшлүүлэх зэрэг үйл ажиллагааг болгон хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тасралтгүй хэрэгжүүлж ирсэн бөгөөд цаашид ч хэрэгжүүлэх зорилго, зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа болно.

Тайлбар 2.7-г үзнэ үү.

Гурав. “УАГ-аас ТЕГ-ын 2010-2012 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитийн тайлан”-гийн төсөлд:

Гүйцэтгэлийн аудитийн тайлангийн 3.27 (Татварын хяналт шалгалтын ажлыг сайжруулах нэг гол асуудал нь давхар хяналтын тогтолцоо бөгөөд УТА-ны хувьд энэхүү тогтолцоо хангалттай үйлчлэхгүй байна. Татварын хяналт шалгалтын ажилд хяналт тавих нэг гол нэгж нь ДАХШҮХ бөгөөд ТЕГ-ын энэхүү нэгж нь 2011 оны 11 сард шинэчилсэн зохион байгуулалтад орж байгуулагдсан байна.), 3.28 (ДАХШҮХ өнөөдрийн байдлаар хэлтэс, албадын үйл ажиллагаанд мониторинг, үнэлгээ хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид

татварын байцаагч, албадын үйл ажиллагаанд давхар хяналт хийж байх зайлшгүй шаардлагатай байна.) гэсэнд дараахи тайлбарыг гаргаж байна.

ТЕГ-ын ДАХШҮХ-ийн хэрэгжүүлэх чиг үүрэгт татварын хяналт шалгалт болон нягтлах (давхар) хяналт шалгалт хийх чиг үүрэг байдаггүй.

ТЕГ-ын даргын 2008 оны 192 дугаар тушаалаар баталсан «Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм»-ийн Нэг дүгээр бүлгийн 1.6 дах заалтад: «ҮТЕГ-ын ХШАЭН нь ҮТА-ны хэмжээнд, Нийслэлийн Татварын газар нь өөрийн болон дүүргүүдийн Татварын хэлтэстэй харилцагч, улсын төсвийн орлого, хяналтын ажил эрхэлсэн нэгж (цаашид "УТОХН" гэх), аймаг, дүүргүүдийн Татварын хэлтэс нь өөрийн харилцагч татвар төлөгчдөд татварын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан хийж гүйцэтгэнэ», Хоёрдугаар бүлгийн 2.4 дэх заалтад: «Татварын нягтлах хяналт шалгалт хийх. 2.4.1.ҮТЕГ-ын ХШАЭН нь хяналт шалгалтын ажлыг Монгол Улсын Татварын Ерөнхий хууль, энэхүү дүрмэнд заасны дагуу ҮТА-ны хэмжээнд зохион байгуулан, татварын хууль тогтоомжийг зөрчсөн тухай үндэслэлтэй гомдол, мэдээллийг үндэслэн, эсхүл хувь хүн, хуулийн этгээдийн хүсэлт, хууль хяналтын байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврын дагуу татварын нягтлах хяналт шалгалтыг хийж болно» гэж заасан бөгөөд 2011 оны 388 дугаар тушаалаар «1.6.ҮТЕГ-ын ХШАЭН нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн тухай аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн, албан тушаалтны гомдол, мэдээлэл хүсэлтээр ТЕГ-ын дарга, асуудал эрхэлсэн дэд даргын шийдвэрээр шаардлагатай тохиолдолд комисс томилуулж...татварын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан хийж гүйцэтгэнэ» гэж өөрчлөлт оруулсан бөгөөд ТЕГ-ын даргын 2008 оны 192 дугаар тушаалаар баталсан «Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм»-ийн 2.4 дэх заалтыг хүчингүй болгосон байна.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Сангийн яамнаас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар 1.1

ТЕГ-аас 2012 оны 1/575, 1/1871, 1/2198 дугаартай албан бичгүүдээр саналаа хүргүүлж байсан байна. Иймд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 1.2

2.9-д "ТЕГ нь хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу татварын төлөвлөгөөг биелүүлэхээр ажиллаж байгаа боловч биелэлтэд үндэслэл муутай, хэт өндөр төлөвлөгөө сөргөөр нөлөөлдөг гэж тайлбарлаж байна" гэж өөрчлөлт хийв.

Тайлбар 1.3

Тайлангийн энэхүү хэсэг ТЕГ-ын Татвар хураалтын хэлтсээс гаргуулсан тоон мэдээлэлд суурилсан ба 2010, 2011, 2012 онуудын III улирлаар зэрэгцүүлснийг тодруулж тусгав.

Тайлбар 1.4

Татварын ерөнхий хуулийн 17.1.4-т зааснаар татвар төлөгчид нь илүү төлсөн татвараа буцаан авах, суутган тооцуулах, алданги нэхэмжлэн авах эрхтэй байдаг. Нөгөө талаас энэхүү асуудлыг татварын орлогын төлөвлөгөө таслах гол шалтгаан гэж үзээгүй бөгөөд харин ирээдүйн татварын болон болон улсын төсвийн орлого тогтвортой хангагдах нөхцлийг бууруулах, сөрөг нөлөөлөл бий болохыг дүгнэсэн байна.

Харин тайлангийн төслийн 2.31-ээс "... татварын орлогын биелэлт дутах нэг нөхцөл болж байна" гэснийг хасав.

Тайлбар 1.5

Ирүүлсэн саналтай нэг байгаа бөгөөд энэхүү асуудлыг орхиогүй, тайлангийн 3.11-д анхааруулга байдлаар тусгасан байна. Иймд нэмэлт хийх шаардлагагүй юм.

Тайлбар 1.6

ҮАГ нь Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2, 15.1.12-т заасан бүрэн эрхийн хүрээнд аудитаа хийсэн бөгөөд энэхүү асуудал ААНОАТ-ын ногдуулалт, төлөлтийг хянах явцад илэрсэн.

Иймд аудитын сэдэв, хамрах хүрээнээс гажсан гэх үндэслэлгүй тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Харин зөвлөмжид "Төрийн банкны дүрэм, Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээ, банкны дотоод журам заавруудыг өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжтой нийцүүлж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, цаашид төрийн үүсгэл санаачлагаар байгуулагдсан нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналт, бодлого, зохицуулалтын арга хэмжээг сайжруулах" гэсэн өөрчлөлт хийв.

Татварын ерөнхий газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Тайлбар 2.1

Ашиглагдаж буй нөөцийг шууд нэмэгдүүлэх замаар бус тогтвортой байдлыг хангах, зарим чиг үүргээ хөнгөвчлөх, бусдаар гүйцэтгүүлэх, татварын тогтолцоог боловсронгуй болгох ажил хоцрогдож байна. Иймд дүгнэлтэд өөрчлөлт хийх шаардлагагүй юм.

Тайлбар 2.2

Тодорхой санал ирүүлээгүй тул дүгнэлтэд өөрчлөлт хийгээгүй болно.

Тайлбар 2.3

Дүгнэлтэд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Тайлбар 2.4

Дүгнэлтэд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Тайлбар 2.5

Тайлангийн 2.57-д “Төсвийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн үр дүнг харгалзсан, зарим хуулийн заалтыг үндэслэл болгосон зэргээр урамшуулал олгож буй энэхүү тогтолцоо, эрх зүйн орчныг өөрчилж боловсронгуй болгох шаардлагатайг тэмдэглэж байна” гэсэн нэмэлт хийв.

Зөвлөмжийг “Урамшуулалд авч буй санхүүжилтыг ТЕГ-ын нэгдсэн тайланд тусгаж СТОУС, НББОУС-ын дагуу иж бүрэн, үнэн зөв илэрхийлэх, тогтолцоо эрх зүйн орчинг өөрчилж, боловсронгуй болгох асуудлыг судалж, санал боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх” гэж өөрчлөв.

Тайлбар 2.6

Татвараас зайлсхийхтэй тэмцэж буй ажлыг үгүйсгээгүй бөгөөд гагцхүү үр дүн багатай, шийдвэрлэлтийн байдал удаашрилтай, тодорхой хэмжээгээр төр, засгийн дэмжлэг хэрэгтэй байгааг тайланд дурдсан байна. Түүнчлэн олон улсын жишгийн дагуу татвараас зайлсхийхтэй тэмцэх тухай тусгайлсан хуулийг Татварын ерөнхий хуулийн 27.6.5-д заасны дагуу саналаа бэлтгэн ажиллах боломж нээлттэй байгааг үүгээр мэдэгдье.

Зөвлөмжид өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Тайлбар 2.7

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Сангийн сайд Ч.Улаанд:

- Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчилж баталгаажуулах,
- Татварын орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах нэгдсэн аргачлал, арга зүйг боловсруулж мөрдүүлэх,
- Төрийн банкны дүрэм, Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээ, банкны дотоод журам заавруудыг өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжтой нийцүүлж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, цаашид төрийн үүсгэл санаачлагаар байгуулагдсан нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналт, бодлого, зохицуулалтын арга хэмжээг сайжруулах,
- Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд байгаа өрийн барагдуулалт, татвараас зайлсхийх, далд эдийн засагтай тэмцэх ажилд дэмжлэг үзүүлэх болон уул уурхайн бүтээгдэхүүний жишиг үнэ тогтоож буй асуудлыг нэг мөр болгох арга хэмжээ авах,
- Татварыг давхардуулан ногдуулахгүй байх тухай олон улстай байгуулсан хэлэлцээрийг бүхэлд хянан үзэж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Батмагнайд:

- ТЕГ-ын стратеги төлөвлөгөө, судалгаа шинжилгээний дүнд үндэслэн орон тооны жишиг норматив, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- УТА-ны зарим чиг үүргийг хөнгөвчлөх, олон нийт, төрийн бус, хувийн хэвшлийн оролцоо хяналтыг нэвтрүүлэх асуудлыг судалж, санал боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- Улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын дэмжлэг, бодлогыг татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, албадын ажлын орчинг сайжруулахад хандуулж төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад анхаарч холбогдох арга хэмжээ авч ажиллах,
- Тайлангийн ирцийн дүнд “Х” болон “алдагдалтай” тайлангийн хувь хэмжээ буурахгүй, түүнчлэн татварын албаны үр ашигт байдлын түвшний үзүүлэлт буурах хандлагатай байгаад дүгнэлт хийж, суурь үзүүлэлтийг ашиглан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Урамшуулалд авч буй санхүүжилтыг ТЕГ-ын нэгдсэн тайланд тусгаж СТОУС, НББОУС-ын дагуу иж бүрэн, үнэн зөв илэрхийлэх, тогтолцоо эрх зүйн орчинг өөрчилж боловсронгуй болгох асуудлыг судалж, санал боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх,
- Маргаан таслах зөвлөлд ирж буй өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдлыг үнэлэх, зөвлөлөөс гаргасан шийдвэрт үнэлэлт дүгнэлт, өгч мэдээлж байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Хөндлөнгийн мэдээлэл, ногдуулалтын хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, УТОХГ-аас бүртгэлтэй татвар төлөгчдөд үзүүлж буй үйлчилгээний үр дүнг үнэлэх, тус газрын бүтэц, чиг үүргийг хянан үзэж боловсронгуй болгох арга хэмжээ авах,
- Татвараас зайлсхийхтэй тэмцэж буй ажлын үр нөлөөг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн лам, Татварын ерөнхий газарт хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, дүнг 2013 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Батмагнай нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал (Б.Баттуяа)-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР




А.ЗАНГАД

070110


Хавсралт №1

ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн схем



Хавсралт №1.1

УТОХГ-ын зохион байгуулалтын бүтцийн схем



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТЭДГЭЭРИЙН АЛБАДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХӨДӨЛГӨӨНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА

Д.д	Татварын албад	Нийт ажиллагсдын тоо /2010.12.31-ний байдлаар/	Хөдөлгөөн, өөрчлөлтийн шалтгаан, Үүнээс								Нийт ажиллагсдын тоо /2012.09.30-ний байдлаар/
			А.Нэмэгдсэн				Б.Буурсан				
			Шинэ ажилтан авсан	Шилжиж ирсэн /бусад газар, хэлтсээс/	Чөлөөнөө орсон	Шилжсэн хөдөлгөөн /бусад газар, хэлтэст	Өөрийн хүсэлтээр гарсан	Халагдсан	Бусад шалтгаанаар	чөлөө авсан	
А	1	2	3	4	5	4	6	7	8	9	
1	ТЕГ	103	15	19	6	4	4		3	2	130
2	УТОХГазар	35	6	28	4		4		2	3	64
3	НТГазар	67		15	3	3	3		2	2	75
4	Баянгол ДТХ	110	5	7	6	8			1	9	110
5	Баянзүрх ДТХ	104	2	8	5	8	2		2	5	102
6	Чингэлтэй ДТХ	94	7	8	4	10	2		1	6	94
7	Сүхбаатар ДТХ	125	3	6	5	6	2		4	7	120
8	Сонгинохайрхан ДТХ	85	5	6	2	11			3	1	83
9	Хан-Уул	77	2	7	1	14	2		1	1	69
10	Багануур	17	2		2					2	19
11	Налайх	14	1	1							16
12	Багахангай		2								2
13	Архангай	46	5		1	3	1		2	1	45
14	Баян-Өлгий	39	1								40
15	Баянхонгор	45			1					1	45
16	Булган	41	3			2					42
17	Говь-Алтай	46	3			1	1		1		46
18	Говьсүмбэр	10	1		1				1		11
19	Дархан-Уул	52	1	1					2		52
20	Дорноговь	52	2			1	1		2	2	48
21	Дорнод	44	3	1		1			2	1	44
22	Дундговь	33	3			2			1		33
23	Завхан	46	2						2		46
24	Орхон	50	2	1			2		1	2	48
25	Өвөрхангай	48	2		1				3	2	46
26	Өмнөговь ТГ	37	14	4	3		1		1		56
27	Сүхбаатар	32	3		1				3		33
28	Сэлэнгэ	53	4		1				1		57
29	Төв	50	2		1				2		51
30	Увс	46	9				1		4	2	48
31	Ховд	50	1			2			1	1	47
32	Хөвсгөл	53	3						3	2	51
33	Хэнтий	42	1		1				3	1	40
СИСТЕМИЙН ДҮН		1746	115	112	49	76	26	-	54	53	1813

УТА-ны системд ажиглаж байгаа албан хаагчдын судалгаа

Д/а	Татварын алба	Батлагдсан орон тоо	2012.06.30-ны байдлаарх нийт албан хаагчид	Үүрэг:		Үүрэг:												Нийт албан хаагчдаас:							
				Төрний үйлчилгээний албан хаагчид	Төрний захирагчийн албан хаагчид	Хяналт шалгалтын хэлтэс /тасаг/	Татвар хуралтын хэлтэс /тасаг/	Татвар төлөгчтэй харилцах хэлтэс /тасаг/	Төрний захиргаа, удирдлагын газар /хэлтэс, тасаг/	Мэд.статистикийн хэлтэс /тасаг/	Эрдэмтйн удирдлагын хэлтэс /тасаг/	Хууль эрх зүйн хэлтэс /тасаг/	Хууль хүний орлогын албан татвар	Мэсэлэн технологийн төв	ТУХАГ	ДАХШТХ	Сурвалжын төв	Сум	Төрний захирага хууль эрх зүйн тасаг	Мэсэлэн бэлдвэрлэлт, эрдэмтйн удирдлагын тасаг	Эрхэлтэс бэлдвэрлэлт, татварын хэлтэс	Ахлах байцаагч /хэлтэсийн дарга эрсдэл/	Хураан	Орон тооны бус байцаагч	
1	ТЭГ	129	130	40	90	6	8	11	36	6	6	9	9	22	12	5	9				28	4	4		
2	УТОХГ	70	64	8	56	21	14	6	3	7	2									11	17	8			
3	НТГ	74	77	13	64	13	18	13	14	5	6	5	3								17	4			
4	БГДТХ	108	110	12	98	29	26	18	12	4	6	2	13								8	4	22		
5	БЗДТХ	101	102	45	57	23	21	12	9	6	6	2	23								7	7	32		
6	БНДТХ	19	19	7	12	3	4	5	4	1	1	1									5	3			
8	НДТХ	16	16	5	11	2	4	3													5	2	8		
9	СХДТХ	82	83	12	71	23	21	12	10	5	5	1	6								8	7	12		
10	СБДТХ	120	120	33	87	31	41	21	13	6	5	3	5								5	6	18		
11	ХУДТХ	68	69	14	55	16	15	12	9	5	5	2	5								9	1	10		
12	ЧДТХ	94	94	18	76	21	34	14	8	6	5	6									9	8	9		
13	Ахламгай ТХ	45	45	12	33	4	3	4					3								18	11	2	1	
14	Баян-Өлгий ТХ	39	40	14	26	4	6	5					5								15	3	2	5	
15	Баянхонгор ТХ	44	45	8	37	3	6	4					4								19	10	3	1	
16	Булган ТХ	41	42	7	35	4	6	4					4								16	9	3	8	
17	Говь-Алтай ТХ	46	46	8	38	4	6	5					5								19	2	10		
18	Говь-Сүмбэр ТХ	11	11	3	8	1	2	2					2								4				
19	Дархан-Уул ТХ	52	52	7	45	8	12	7	8	3	3	2	5								6	1			
20	Дорноговь ТХ	47	48	11	37	5	6	5					5								21	9	2	4	
21	Дундговь ТХ	33	33	5	28	4	5	4					4								14	4	2	5	
22	Дорнод ТХ	44	44	10	34	4	9	5					5								13	10	3	5	
23	Завхан ТХ	46	46	7	39	4	5	3					3								23	6	3	4	
24	Орхон ТХ	47	48	14	34	12	14	9	3	3	4	2	2								1			9	
25	Өмнөговь ТГ	54	56	26	30	4	8	5	10	4	3	1									21			8	
26	Өвөрхангай ТХ	46	46	13	33	4	8	4					4								22	5	3	2	
27	Сүхбаатар ТХ	33	33	11	22	4	5	3					3								14	4	3	5	
28	Сэлэнгэ ТХ	57	57	5	52	5	12	5					5								25	8	2	7	
29	Төв ТХ	51	51	9	42	4	5	4					4								26	10	2	4	
30	Увс ТХ	48	48	10	38	5	6	4					4								18	7	3	2	
31	Хөвд ТХ	47	47	8	39	6	10	6					5								15	6	2	4	
32	Хөвсгөл ТХ	51	51	12	39	4	12	4					4								24	4	3	7	
33	Хэнтий ТХ	40	40	8	32	4	3	5					3								21	2	2	1	
ТЕГ		129	130	40	90	6	8	11	36	6	6	9	9	22	12	5	9				28	4	4		
Нийслэл		752	754	167	587	182	198	111	82	38	46	24	50								5	2	11	91	
Аймаг		922	929	208	721	97	149	97	21	10	10	5	21								349	120	50	121	
НИИТ		1803	1813	415	1398	205	355	224	139	54	62	38	71	22	12	5	9				349	125	52	240	
																									140
																									138

ҮТА-ХУУЛИЙН ДАГУУ ТӨВЛӨРҮҮЛЭХ ТАТВАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ӨСӨЛТ
(Өмнөх тайлант жилүүдтэй харьцуулсан хувиар)

д/д	Татварын алба	2003-2009 онд төлөвлөлтийн дундаж өсөлт	Өмнөх он тус бүртэй харьцуулснаар:			2012 оны 6 сар/2011 оны 6 сар
			2010/2009	2011/2010	2012/2011*	
	НИЙТ	138,3	167,3	151,8	118,2	156,3
1	Архангай	127,8	93,5	126,0	133,5	159,3
2	Баян-Өлгий	118,5	119,0	124,5	131,8	134,4
3	Баянхонгор	126,5	114,2	132,6	131,9	105,7
4	Булган	132,5	105,7	139,9	106,1	103,5
5	Говь-Алтай	136,9	148,1	145,9	161,1	136,6
6	Дорноговь	128,0	120,2	126,4	139,9	161,9
7	Дорнод	129,0	122,8	118,3	130,4	119,0
8	Дундговь	121,6	126,9	120,1	106,9	133,3
9	Завхан	119,8	113,6	106,7	127,5	138,1
10	Өвөрхангай	122,2	107,1	149,8	126,5	163,7
11	Өмнөговь	188,2	194,2	222,0	116,0	180,5
12	Сүхбаатар	305,0	227,6	103,4	113,3	107,9
13	Сэлэнгэ	134,4	139,3	113,2	105,5	134,9
14	Төв	142,0	102,1	130,9	96,9	155,2
15	Увс	131,9	207,3	117,2	92,9	131,0
16	Ховд	123,7	108,0	139,6	219,6	150,0
17	Хөвсгөл	115,6	114,2	148,4	122,3	141,9
18	Хэнтий	135,0	154,4	107,2	145,8	135,2
19	Дархан-Уул	117,4	118,4	116,4	158,1	160,7
20	Орхон	148,2	132,0	218,9	115,5	81,0
21	Говьсүмбэр	121,7	143,8	112,1	98,6	154,2
22	ТЕГ, УТОХГ	147,7	199,4	150,0	106,8	144,5
23	НТГазар	111,6	136,7	118,5	206,7	256,5
24	Хан-Уул ДТХ	138,8	138,2	127,2	160,8	181,6
25	Баянзүрх	134,9	116,6	155,9	148,5	223,7
26	Сүхбаатар	146,2	113,9	184,6	155,9	270,8
27	Баянгол	129,6	118,6	134,6	158,5	245,8
28	Багануур	117,0	132,5	126,8	141,5	174,0
29	Налайх	131,1	122,0	153,2	132,0	189,9
30	Сон.хайрхан	129,1	116,9	128,6	148,5	202,9
31	Чингэлтэй	138,4	86,7	179,7	137,5	215,2

*Тодотгосон төлөвлөгөөтэй харьцуулсан болно.

Хавсралт №3.1

ҮТА-ХУУЛИЙН ДАГУУ ТӨВЛӨРҮҮЛЭХ ТАТВАРЫН ТӨЛӨВЛӨСӨН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Д.д	Татварын албад	2002-2009 оны гүйцэтгэлийн дундаж /хувиар/	2010 он		2011 он		2012 оны эхний 6 сарын байдлаар	
			Дүн /сая.төг/	Хувь	Дүн /сая.төг/	Хувь	Дүн /сая.төг/	Хувь
	НИЙТ	114,7	1 545 900,1	112,1	2 167 973,8	102,5	1 212 871,1	92,0
1	Архангай	105,9	3 529,1	114,1	4 687,1	120,2	3 192,1	128,6
2	Баян-Өлгий	117,9	3 510,3	116,9	4 396,4	117,6	2 808,5	127,5
3	Баянхонгор	103,8	3 618,2	109,2	4 994,7	109,4	2 776,2	127,6
4	Булган	105,4	5 652,8	106,1	6 913,8	99,4	3 781,6	106,5
5	Говь-Алтай	120,1	5 002,6	110,5	7 814,0	118,3	5 555,7	107,7
6	Дорноговь	115,9	9 372,3	104,0	11 630,6	102,1	7 580,6	105,3
7	Дорнод	114,1	7 312,9	112,7	10 702,4	138,8	5 099,9	146,0
8	Дундговь	121,4	3 679,8	114,8	4 115,9	118,3	2 323,2	124,3
9	Завхан	124,4	3 208,3	110,6	4 089,2	132,1	2 518,5	122,5
10	Өвөрхангай	112,4	4 319,4	133,7	5 882,8	121,5	3 428,1	128,9
11	Өмнөговь	144,4	42 937,5	90,1	108 446,1	102,5	44 054,8	114,9
12	Сүхбаатар	120,2	8 226,9	104,1	8 589,7	105,2	5 277,5	148,6
13	Сэлэнгэ	104,2	16 706,8	402,6	15 588,8	79,2	10 441,2	114,7
14	Төв	117,2	7 215,6	100,7	10 061,2	86,7	5 236,8	133,3
15	Увс	129,4	8 636,1	109,5	9 705,9	105,0	4 153,6	85,8
16	Ховд	119,5	4 382,7	132,7	5 639,7	122,3	4 903,6	112,0
17	Хөвсгөл	119,4	4 553,6	126,4	6 203,6	116,1	4 028,4	123,6
18	Хэнтий	157,3	7 811,1	224,5	9 192,7	145,1	4 833,8	118,4
19	Дархан-Уул	108,4	11 084,9	216,6	13 152,7	111,5	7 913,2	88,4
20	Орхон	122,7	37 526,5	107,6	72 943,9	107,0	33 818,6	127,1
21	Говьсүмбэр	120,7	3 611,1	112,2	3 266,5	93,6	1 816,3	94,7
22	УТОХГ	110,7	1 035 448,8	110,7	1 410 446,8	100,5	724 255,1	82,7
23	НТГазар	114,2	58 487,9	116,6	66 846,9	112,4	67 541,0	137,1
24	Хан-Уул	112,0	38 837,1	107,8	48 047,8	106,2	31 903,0	109,6
25	Баянзүрх	107,4	27 869,5	108,2	40 908,4	103,8	29 964,3	97,9
26	Сүхбаатар	124,0	76 750,5	119,5	124 144,9	107,0	89 894,4	104,4
27	Баянгол	106,2	40 539,9	103,4	54 494,9	104,8	38 836,0	87,1
28	Багануур	110,2	4 473,4	121,4	5 440,8	116,5	3 307,1	104,0
29	Налайх	115,4	1 705,1	105,9	2 586,1	109,1	1 659,4	102,4
30	Сонгино хайрхан	109,1	16 390,1	102,8	21 116,8	104,5	15 431,6	95,0
31	Чингэлтэй	121,4	43 499,2	125,6	65 922,7	108,3	44 537,1	110,3

Хавсралт №4

УТА-ТАТВАР ТӨЛӨГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН СУДАЛГАА*

Төрөл	Хариуц-лагын хэлбэр	2002 оны эцэст	2006 оны эцэст	2008 оны эцэст	2010 оны эцэст	2012 оны			
						Эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	6 сарын байдлаар
Аж ахуйн нэгж	ХК	407	390	351	343	345	9	2	352
	ХХК	17 173	35 690	48 803	62 012	72 361	6 395	243	78 519
	Хоршоо, нөхөрлөл	5 826	6 195	5 279	5 047	5 382	71	29	6 098
	ТӨҮГ	255	203	174	167	164	3	-	167
	ОНӨҮГ	125	148	165	181	192	20	1	211
	Салбар	980	1604	3 246	4 435	4 739	264	56	4 953
	Төлөөлөгчийн газар	8	33	25	30	30	2	-	32
	Давхар нэгж*	-	376	-	-	154	7	-	161
Дүн	24 774	44 639	58 043	72 215	83 367	7 444	331	90 493	
Төсөвт болон ТББ	Төсөвт байгууллага	4 132	4219	4 398	4 551	4 637	117	8	4 746
	Төрийн бус байгууллага	296	1686	2 635	4 222	5 574	1005	22	6 557
	Олон нийтийн байгууллага	1253	1380	1 428	1 541	1 620	104	5	1 721
	Шашны байгууллага	143	245	308	384	412	27	3	436
	Сан	86	154	195	284	364	54	3	415
	Дүн	5 910	7 684	8 964	10 982	12 607	1 307	41	13 875
Нийт	30 684	52 323	67 007	83 197	95 974	8 751	372	104 368	

*Эх сурвалж: ТЕГ-ын Татвар төлөгчийн танилцуулга, Мэдээлэл боловсруулалт, автоматжууллагын хэлтэс

Хавсралт №4.1

УТА-ТАТВАР ТӨЛӨГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТАЙЛАНГИЙН ИРЦИЙН МЭДЭЭ
(Татварын төрөл, он)

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлан ирүүлбэл зохих ТТХЭ-ийн тоо	Тайлан ирүүлсэн ТТХЭ-ийн тоо	Үүнээс:			Тайлан ирүүлээгүй ТТХЭ-ийн тоо	Ирцийн хувь	
			"Х" Тайлан ирүүлсэн	Алдагдалтай тайлан ирүүлсэн	Бусад*			
ААНОАТ	2006 он	34 500	30 579	8 726	4 917	16 936	3 921	88.6
	2008 он	48 592	42 943	15 450	6 941	20 552	6 121	88.4
	2010 он	62 232	55 535	22 831	9 390	23 314	6 697	89.2
	2012 он	<u>79 833</u>	<u>65 962</u>	<u>29 635</u>	<u>10 675</u>	<u>25 652</u>	<u>13 871</u>	<u>82.6</u>
НӨАТ	2006 он	5 765	5 604	1 136	-	-	160	97.2
	2008 он	8 738	8 365	1 916	-	-	374	95.7
	2010 он	26 119	24 961	6 726	-	-	1 158	95.6
	2012 он	<u>25 246</u>	<u>23 625</u>	<u>7 907</u>	-	-	<u>1 620</u>	<u>93.6</u>
ОАТ	2006 он	158	145	-	-	-	13	91.8
	2008 он	132	124	-	-	-	9	93.4
